


Хамтдаа
хөгжсөн 20 жил
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



МОНГОЛ
УЛСЫН
ЭХЭМЖИГ
ХАМГААГАХ
МОНГОЛ
УЛСЫН
ЭХЭМЖИГ



САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ

2026 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРАЛ

АГУУЛГА

I

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

11

Зах зээлийн төлөв
ХАА–н гаралтай бараа, түүхий эдийн зах зээл
Биржийн бус зах зээл
Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээл
Ашигт ажиллагаа
Тогтвортой байдал
Бодлого зохицуулалт

II

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

34

Зах зээлийн төлөв
Хүртээмжтэй байдал
Бүтээгдэхүүн үйлчилгээ
Ашигт ажиллагаа
Тогтвортой байдал
Бодлого зохицуулалт

III

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

52

Зах зээлийн төлөв
Хүртээмжтэй байдал
Бүтээгдэхүүн үйлчилгээ
Ашигт ажиллагаа
Тогтвортой байдал
Финтек
Ногоон зээл
Бодлого зохицуулалт

IV

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

74

Зах зээлийн төлөв
Хүртээмжтэй байдал
Бүтээгдэхүүн үйлчилгээ
Ашигт ажиллагаа
Тогтвортой байдал
Бодлого зохицуулалт

V

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ

90

Зах зээлийн төлөв
Хүртээмжтэй байдал
Бодлого зохицуулалт

VI

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

98

Зах зээлийн төлөв
Хүртээмжтэй байдал
Бүтээгдэхүүн үйлчилгээ
Ашигт ажиллагаа
Тогтвортой байдал

VII

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ

106

Зах зээлийн төлөв
Хүртээмжтэй байдал
Бүтээгдэхүүн үйлчилгээ
Ашигт ажиллагаа
Бодлого зохицуулалт

VIII

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧ

120

Зах зээлийн төлөв
Хүртээмжтэй байдал
Бүтээгдэхүүн үйлчилгээ
Ашигт ажиллагаа
Бодлого зохицуулалт

IX

СЭНДБОКСЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

130

Сэндбоксын орчин
Бодлого зохицуулалт

X

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЗАХ ЗЭЭЛ

136

Зах зээлийн төлөв
Хүртээмжтэй байдал
Бүтээгдэхүүн үйлчилгээ
Ашигт ажиллагаа

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж	ҮХЭХБХСЗ	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлал
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	ҮХЭХЗ	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал
АНУ	Америкийн Нэгдсэн Улс	ҮЦК	Үнэт цаасны компани
АХБ	Азийн хөгжлийн банк	ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага	ХАА	Хөдөө аж ахуй
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс	ХААБ	Хөдөө аж ахуйн бирж
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	ХБУЦ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт	ХЖДХ	Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү
ВХҮҮ	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч	ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо
ГҮТББ	Гишүүдэд үйлчлэх төрийн бус байгууллага	ХК	Хувьцаат компани
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн	ХНХИ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр	ХОМК	Хөрөнгө оруулалтын менежментийн компани
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан	ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас	ХХААДЗ	Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү	ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЗМС	Зээлийн мэдээллийн сан	ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МЗҮАЭ	Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч		
МИК	Монголын ипотекийн корпораци		
МУТСТ	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх		
МХБ	Монголын хөрөнгийн бирж		
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл		
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо		
СМА	Санхүүгийн мэдээллийн алба		
ТДЦА	Татварын дараах цэвэр ашиг		
ТЗК	Тусгай зориулалтын компани		
ТОС	Тогтвортой санхүүжилт		
УБУЦБ	Улаанбаатар үнэт цаасны бирж		
УИХ	Улсын Их Хурал		
ҮМҮЧЭТХЭАЭ	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч		
		Латин товчлол	
		AFI	Alliance for Financial Inclusion (Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг)
		B2B	Business to Business
		GIZ	Германы хамтын ажиллагааны нийгэмлэг
		IPO	Initial Public Offering (Олон нийтэд хувьцаагаа санал болгох)
		MSE	Mongolian Stock Exchange (Монголын хөрөнгийн бирж)
		OTC	Over the Counter
		P2P	Peer to Peer
		ROA	Return on Assets (Нийт хөрөнгийн өгөөж)
		ROE	Return on Equity (Өөрийн хөрөнгийн өгөөж)



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Зах зээлийн үнэлгээ

13,690.1

тэрбум төгрөг

ЗЗҮ/ДНБ 15.2%

Уул уурхайн
бүтээгдэхүүний
арилжааны хэмжээ

2,369.8 тэрбум төгрөг

ҮЦК-ийн тоо

52

Арилжааны дүн

348.9 тэрбум төгрөг

ТОП-20 индекс

52,126.33

Хөрвөх чадвар

0.5%

MSE A

20,154.75

MSE B

14,438.18



ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Нийт хөрөнгө

804.1

тэрбум төгрөг

Даатгалын гэрээний тоо

720,473

Нөөц сан

370.2

тэрбум төгрөг

Нягтрал

163,223 төгрөг

Даатгалын
компанийн тоо

22

Цэвэр ашиг

10.2 тэрбум төгрөг

Даатгалын нөхөн төлбөр

47.9

тэрбум төгрөг

Давхар даатгалын
хураамжийн зардал

44.8 тэрбум төгрөг

Даатгалын болон давхар
даатгалын нийт хураамж

143.4

тэрбум төгрөг



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Нийт хөрөнгө

9.6 их наяд төгрөг

578 ББСБ

88.9%

Зээлийн үйл
ажиллагааны тусгай
зөвшөөрөлтэй

4.3 сая
Харилцагч

Нийт зээл

7.8
их наяд төгрөг

Нийт зарлага

500.2 тэрбум төгрөг

Нийт зээлдэгч

3.5
сая

Зээлийн жигнэсэн
дундаж хүү

3.6%

Нийт орлого

772.1
тэрбум төгрөг



ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Нийт хөрөнгө

390.0
тэрбум төгрөг

Чанаргүй зээлийн
нийт зээлд эзлэх хувь

4.4%

172 ХЗХ

Нийт хадгаламж

271.3
тэрбум төгрөг

78,608
Гишүүн

Цэвэр ашиг

3.3 тэрбум төгрөг

Нийт зээл
312.5
тэрбум төгрөг

2.5%

Зээлийн жигнэсэн
дундаж хүү

Хугацаатай хадгаламжийн
жигнэсэн дундаж хүү

1.4%

January

February

March

April

May

June

July

August



МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ

Хүүгийн дээд хязгаар

4.5%

Улсын хэмжээнд

628 МЗҮАЭ

Хуулийн этгээд

395

Иргэн

233



ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Нийт хөрөнгө

305.8
тэрбум төгрөг

Батлан даалтын хэмжээ

3.4
тэрбум төгрөг

Батлан даалтын дундаж хэмжээ **54.5** сая төгрөг

Хүсэлтийн тоо

62

Чанаргүй батлан даалтын багцад эзлэх хувь

1.9%



ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ

ҮХЭХЗ-ын байгууллага

298

Зуучлан худалдсан

794.8

тэрбум төгрөг

Зуучлан түрээслүүлсэн **61.4** тэрбум төгрөг



ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИД

Хуулийн этгээд **54**

Иргэн **522**

Үнэт металл худалдан авалт

202.5

тэрбум төгрөг

Үнэт металлын борлуулалт

208.9 тэрбум төгрөг



СЭНДБОКСЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

Нийт ирүүлсэн хүсэлт

25



Амжилттай туршигдсан **3**
Туршигдаж буй **4**

Репо хэлцэл зуучлалын үйлчилгээ

Нийт арилжааны дүн **560.4**

Удаагийн хэлцэл **2,550**

P2P зээлийн үйлчилгээ

11,968 харилцагчид
4.4 тэрбум төгрөг

B2B зээлийн үйлчилгээ

345 харилцагчид
197.1 тэрбум төгрөг



ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЗАХ ЗЭЭЛ

Виртуал хөрөнгийн
үйлчилгээ
үзүүлэгчийн тоо

12

Харилцагчийн тоо

Идэвхитэй харилцагчдын тоо

724,671
18,770

Дотоод виртуал хөрөнгийн
зах зээлийн үнэлгээ

188.9 тэрбум төгрөг

Дотоодын виртуал хөрөнгийн
өдрийн дундаж арилжаа

340.0
сая төгрөг

Дотоодын виртуал
хөрөнгийн тоо

36

Дотоодын виртуал хөрөнгийн
арилжааны дүн

30.6 тэрбум төгрөг

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ



ЗАХ ЗЭЭЛИЙН
ТӨЛӨВ

Зах зээлийн үнэлгээ

13,690.1 тэрбум
төгрөг



ХҮРТЭЭМЖТЭЙ
БАЙДАЛ

Дансны тоо

2,612,223



БҮТЭЭГДЭХҮҮН
ҮЙЛЧИЛГЭЭ

Нийт арилжааны дүн

348.9 тэрбум
төгрөг



АШИГТ АЖИЛЛАГАА

ҮЦК-ийн ашиг
10.2 тэрбум
төгрөг

Улсад татан төвлөрүүлсэн
татвар, НДШ (ҮЦК, ХОМК)

6.2 тэрбум
төгрөг



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Төвлөрөл
33Ү-ний 90.5 хувийг
Топ-20 ХК



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ



Үнэт цаасны
зах зээлд
НИЙТ 641
зохицуулалттай этгээд,
хувьцаат компани
үйл ажиллагаа
эрхэлж байна

Хувийн хөрөнгө оруулалтын
сан (Хөрөнгө оруулалтын
сангийн тухай хуулийн
5.3 дахь заалт)

48

Мэргэжлийн холбоо, өөрийгөө
зохицуулах байгууллага

1

Дэд бүтцийн байгууллага

Арилжаа эрхлэх байгууллага 3	Үнэт цаасны клирингийн байгууллага 2 /2 давхардсан/	Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн байгууллага 4
Үнэт цаасны төлбөрийн байгууллага 1 /давхардсан/	Уул уурхайн бүтээгдэхүүний бирж 1 /давхардсан/	ХАА–н бирж 1

Мэргэжлийн оролцогч

ҮЦК 52	ХОМК 38	Хамтын хөрөнгө оруулалтын сан 9
Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч 15 /10 давхардсан/	ХАА–н түүхий эдийн брокер 9	Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох байгууллага 4

Андеррайтерийн зөвшөөрөлтэй банк
2 /1 давхардсан/

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч 74 /ТЗК/	Хөрөнгө итгэмжлэн удирдах 5	Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэл хянагч 2 /1 давхардсан/
--	--	--

Бүртгэлтэй этгээд


ҮЦЗЗ–д аудитын үйлчилгээ үзүүлэх 58 /5 давхардсан/	ҮЦЗЗ–д хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх 25 /давхардсан/	ҮЦЗЗ–д хуулийн үйлчилгээ үзүүлэх 50
---	--	--

СЗХ–нд бүртгэлтэй ХК
307

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй – 162 ХК
Улаанбаатар үнэт цаасны биржид бүртгэлтэй – 2 ХК

*ҮЦК–д брокер, дилер, андеррайтер болон хөрөнгө оруулалтын
зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагыг хамруулна.

Үнэт цаасны арилжаа /тэрбум төгрөг/




Үнэт цаасны зах зээлийн арилжаа

- 2026 оны 1 дүгээр улиралд 348.9 тэрбум төгрөгийн үнэт цаас зах зээлд арилжигдсан нь өмнөх оны мөн үеэс 69.0 хувиар, 2022 оны мөн үеэс 2.9 дахин өссөн үзүүлэлт юм.
- Нийт арилжааны 19.7 хувийг хувьцааны, 22.9 хувийг хөрөнгө оруулалтын сан (ХОС)–гийн нэгж эрхийн, 12.2 хувийг компанийн бондын, 28.0 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ)–ны, 17.2 хувийг Засгийн газрын дотоод үнэт цаас (ЗГДҮЦ)–ны арилжаа тус тус эзэлж байна.

Зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадвар

- Тайлант улиралд зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.7 хувиар өсөж 13,690.1 тэрбум төгрөгт хүрсэн бол хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны хөрвөх чадвар 0.5 хувь байна.


**ТОП 20 52,126.33****MSE A 20,154.75****MSE B 14,438.18****Үнэт цаасны зах зээлийн индекс**

- ТОП-20 индекс** өмнөх оны мөн үетэй харьцуулахад **1,954.95** нэгжээр буюу 3.9 хувиар өссөн;
- MSE A** индекс өмнөх оны мөн үеэс **732.16** нэгжээр буюу 3.8 хувиар өссөн;
- MSE B** индекс өмнөх оны мөн үеэс **290.95** нэгжээр буюу 2.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД БҮРТГЭЛТЭЙ ХК-УУДЫН САЛБАРЫН АНГИЛАЛ

ТОП-20 индексийн багцыг зах зээлийн үнэлгээ, арилжааны өдрийн дундаж гүйлгээ, арилжаанд орсон өдрийн тоо, төвлөрлийн байдал гэсэн шалгуур үзүүлэлтэд үндэслэн бүрдүүлдэг. Бүртгэлтэй компаниудын 23.1 хувийг, ТОП-20 индексийн багцын 66.7 хувийг банк санхүүгийн салбар бүрдүүлж байна.

ТОП-20 ИНДЕКСТ БАГТАХ ХК-УУДЫН САЛБАРЫН АНГИЛАЛ /ЗЗҮ-ЭЭР/




ҮЦТХТ-д БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС



ХУВЬЦААНЫ ӨМЧИЙН БҮТЭЦ

Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй 307 ХК-ийн өмчийн бүтцийг задлан харвал 88.9 хувь нь хувийн өмчит, 6.9 хувь нь төрийн өмчит, 4.2 хувь нь төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой байна.



ҮНЭТ ЦААСНЫ ДАНСНЫ ТОО

Шинээр 1,689 данс нээгдэж нийт дансны тоо **2,612,223**-т хүрсэн бол 11,693 холболтын данс нээгдэж нийт **732,051**-т хүрлээ.



НЭЭГДСЭН ДАНСНЫ ТОО




ДАНСНЫ ТОО
(өссөн дүнгээр)

2,612,223

АРИЛЖААНЫ БҮТЭЦ /НИЙТ АРИЛЖААНЫ ДҮНГЭЭР/

Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй 307 ХК-ийн өмчийн бүтцийг задлан Арилжаа эрхлэх байгууллагууд болон хамтын нээлттэй ХОС-гуудаар дамжуулан арилжаанд оролцогчдын дийлэнх хувь буюу 70.8 хувийг дотоодын иргэний хийсэн гүйлгээ эзэлж байгаа нь тэдний үнэт цаасны зах зээлийн идэвхжилт өндөр байгааг илтгэж байна. Харин дотоодын ААН-ийн хийсэн арилжааны гүйлгээ 27.5 хувь, гадаадын ААН-ийн хийсэн арилжааны гүйлгээ 1.1 хувь, гадаадын иргэний хийсэн арилжааны гүйлгээ 0.6 хувь тус тус эзэлж байна.



АРИЛЖААНД ОРОЛЦОГЧИЙН ТОО, ДАВТАМЖ


Арилжаанд давтагдсан тоогоор нийт 167,669 иргэн, 629 ААН оролцож, 1,219,167 удаагийн арилжаа хийжээ. Хөрөнгө оруулагчдын 99.5 хувийг дотоодын иргэн, 0.3 хувийг дотоодын ААН, 0.2 хувийг гадаадын иргэн, 0.02 хувийг гадаадын ААН тус тус эзэлж байна.



	Арилжаанд оролцсон тоо /давхардсан/		Арилжаанд оролцогчийн тоо	
Гадаадын ААН	271	0.02%	33	0.02%
Гадаадын иргэн	1,341	0.1%	287	0.2%
Дотоодын ААН	3,742	0.3%	596	0.3%
Дотоодын иргэн	1,213,813	99.6%	167,382	99.5%
НИЙТ	1,219,167	100%	168,298	100.0%


ҮЦК БАЙРШИЛ

- Улаанбаатар хотод 52 ҮЦК үйл ажиллагаа эрхэлж байна.



ҮЦК-ИЙН САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН БАЙРШИЛ

- ҮЦК-ийн 37 салбар, төлөөлөгчийн газар үйл ажиллагаа эрхэлж буйгаас 36 нь орон нутагт, 1 нь Улаанбаатар хотод байршиж байна.




ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД

48.7%



51.3%

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД (Насны бүлгээр)



Нийт хөрөнгө оруулагчдын 32.3 хувийг 26–35 насны, 27.6 хувийг 36–45 насны, 13.9 хувийг 18–25 насны, 12.5 хувийг 46–55 насны, 9.8 хувийг 55–аас дээш насны, 3.9 хувийг 0–18 насны иргэд тус тус эзэлж байна.

ҮЦК, ХОМК–ИЙН АЖИЛЧИД

43.9%



56.1%


ҮЦК, ХОМК–ийн нийт ажилчдын 43.9 хувийг эрэгтэй, 56.1 хувийг эмэгтэй ажилчид бүрдүүлж байна.

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ


ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

Нийт хувьцааны арилжаа 68.9 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43.7 хувиар өсөж, 2022 оны мөн үетэй харьцуулахад 27.8 хувиар буурчээ.

■ Хувьцааны арилжаа /тэрбум төгрөг/



Компанийн өрийн хэрэгслийн арилжаа /тэрбум төгрөг/




КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН АРИЛЖАА

Компанийн бондын арилжаа 42.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.7 хувиар буурч, 2022 оны мөн үетэй харьцуулахад 2.4 дахин өсжээ.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН АРИЛЖАА

ХОС-ийн арилжаа 79.9 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.3 дахин, 2022 мөн үетэй харьцуулахад 66.0 дахин өсжээ.


Хөрөнгө оруулалтын сангийн арилжаа /тэрбум төгрөг/



ШИНЭЭР ГАРГАСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН АРИЛЖАА /НЭЭЛТТЭЙ ХҮРЭЭНД/

Гаргасан компани	Бүртгэсэн огноо	ХОС-гийн дүн /тэрбум төгрөг/
"ТУС хуримтлал хамтын нээлттэй ХОС" ХХК	2026.01.22	1.0

Хөрөнгөөр баталгаажсан үнэт
цаасны арилжаа /тэрбум төгрөг/



ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

ХБҮЦ-ны арилжаа 97.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30.9 хувиар, 2022 оны мөн үетэй харьцуулахад 18.3 дахин өсжээ.

ШИНЭЭР ГАРГАСАН КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН АРИЛЖАА

Гаргасан компани	Бүртгэсэн огноо	ХБҮЦ-ны дүн /тэрбум төгрөг/
“Булл капитал Эй Би Эс ТЗК” ХХК	2025.12.11	18.0
“Инвескор өсөлт ТЗК” ХХК	2025.12.25	50.0
“Магна актив ТЗК” ХХК	2026.02.12	14.0


ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

Засгийн газрын дотоод үнэт цаас (ЗГДҮЦ)-ны арилжаа 60.0 тэрбум төгрөг байна.




ГАДААД АРИЛЖААНЫ ТАЙЛАН

2026 оны 1 дүгээр улирлын байдлаар гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй 9 үнэт цаасны компанид бүртгэлтэй 6,942 харилцагч байгаагаас 1,243 харилцагч гадаад улсын үнэт цаасны зах зээлийн арилжаанд оролцож нийт 2,371.0 тэрбум төгрөгийн арилжаа хийжээ.



Тайлант улиралд нийт 2,371.0 тэрбум төгрөг гадаад арилжаа хийгдсэн бөгөөд нийт арилжааны 61.8 хувийг дотоодын иргэн, 20.1 хувийг дотоодын ААН, 16.3 хувийг гадаадын иргэн, 0.8 хувийг гадаадын ААН, 1.0 хувийг ҮЦК-ийн өөрийн нэрийн өмнөөс хийсэн арилжаа тус тус эзэлж байна.



ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ




ХААБ–ээр нийт 5 төрлийн 77.2 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 23.9 тэрбум төгрөгөөр буюу 44.8 хувиар өссөн.





ХАА–Н БРОКЕРЫН КОМПАНИУДЫН БАЙРШИЛ

- 9 ХАА–н брокер үйл ажиллагаа явуулж байгаагийн 7 нь Улаанбаатар хотод, 2 нь орон нутагт байршиж байна.



БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛ

2026 оны 1 дүгээр улиралд биржийн бус зах зээлд нийт 33 үнэт цаас гаргагчийн 589.8 тэрбум төгрөг, 68.0 ам.долларын үнийн дүн бүхий 34 хөтөлбөр бүртгэгдэж, 139 өрийн хэрэгсэл 458.2 тэрбум төгрөг, 8.5 ам.долларын үнийн дүн бүхий санхүүжилтийг тус тус амжилттай татан төвлөрүүлжээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад татан төвлөрүүлсэн үнийн дүн төгрөгөөр 1.9 дахин өссөн, ам.доллараар 3.7 дахин буурсан үзүүлэлт юм.



Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс буюу 2021 оны 09 дүгээр сараас 2026 оны 1 дүгээр улирал хүртэлх хугацаанд нийт 225 үнэт цаас гаргагчийн 464 хөтөлбөр бүртгэгдлээ. Тухайлбал, 7,155.7 тэрбум төгрөг, 330.9 сая ам.долларын үнийн дүн бүхий 1,392 өрийн хэрэгсэл 5,460.9 тэрбум төгрөгийн, 189.9 сая ам.долларын санхүүжилтийг тус тус амжилттай татан төвлөрүүлжээ. Нийт 2,063.4 тэрбум төгрөг, 108.9 сая ам.долларыг эргэн төлсөн байна.



БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоонд бүртгэлтэй биржийн бус зах зээлийн арилжаанд оролцох эрхтэй бүртгэлтэй шууд оролцогч нийт 38 байна. Үүнээс давхардсан тоогоор андеррайтер 24, дилер 23, брокер 30, ХОС 6 компани байна. Харин шууд оролцогч нарт бүртгэлтэй шууд бус оролцогч хувь хүн 5,684, хуулийн этгээд 505 байна.

АНДЕРРАЙТЕР

24

ДИЛЕР

23

БРОКЕР

30

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

6

ХУВЬ ХҮН


5,684

ХУУЛИЙН ЭТГЭЭД

505

БОНДЫН САЛБАРЫН АНГИЛАЛ


Тайлант улиралд нийт бондын 49.5 хувийг санхүүгийн салбар, 19.9 хувийг барилга, 17.0 хувийг уул уурхай, 3.9 хувийг худалдаа үйлчилгээ, 3.6 хувийг үйлдвэрлэл, 2.2 хувийг боловсрол, эрүүл мэнд, 0.3 хувийг эрчим хүч, 0.2 хувийг бусад салбар тус тус эзэлж байна.



Санхүүгийн салбарын бондын 51.0 хувийг хөрөнгө оруулалтын компани, 26.0 хувийг ББСБ, 21.0 хувийг барьцаалан зээлдүүлэх газар, 2.0 хувийг үнэт цаасны компани тус тус эзэлж байна.


БОНДЫН ХУГАЦАА:

Тайлант хугацаанд бүртгэгдсэн нийт бондын 53 хувийг 6–12 сарын хугацаатай, 23 хувийг 18 сарын хугацаатай, 17 хувийг 24 сарын хугацаатай, 7 хувийг 36 сар ба түүнээс дээш сарын хугацаатай бонд тус тус бүрдүүлээ.



УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛ

Тайлант улиралд уул уурхайн бүтээгдэхүүний биржээр нийт 212 удаагийн арилжаагаар 7.6 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 2,369.8 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад биет хэмжээгээр 2.7 дахин, үнийн дүнгийн хувьд 3.6 дахин өссөн үзүүлэлт юм.




Нийт арилжааны үнийн дүнгийн 80.7 хувийг нүүрсний арилжаа, 12.5 хувийг төмрийн хүдэр болон баяжмалын арилжаа, 6.8 хувийг хувийг зэсийн баяжмалын арилжаа тус тус эзэлж байна.

Бүтээгдэхүүний төрөл	Багцын тоо	Хэмжээ /мянган тонн/	Нийт үнийн дүн /тэрбум төгрөг/
Нүүрс	976	6,246.4	1,914.0
Төмрийн хүдэр, баяжмал	402	1,326.6	295.6
Зэсийн баяжмал	16	16.0	160.2
Нийт	1,394	7,589.0	2,369.8

ТӨМРИЙН ХҮДЭР, БАЯЖМАЛЫН АРИЛЖАА

Нийт 402 багц буюу 1,326.6 мянган тонн төмрийн хүдэр болон баяжмалыг 295.6 тэрбум төгрөгөөр арилжлаа. Нийт арилжааны 67.3 хувийг Fe – 58%-ийн төмрийн баяжмал, 26.6 хувийг Fe – 52%-ийн төмрийн баяжмал, 6.1 хувийг Fe – 65%-ийн төмрийн баяжмал тус тус эзэлж байна.



■ Fe-52% Төмрийн хүдэр ■ Fe-58% Төмрийн баяжмал ■ Fe-65% Төмрийн баяжмал

НҮҮРСНИЙ АРИЛЖАА

Нийт 976 багц буюу 6,246.4 мянган тонн нүүрсийг 1,914.0 тэрбум төгрөгөөр арилжлаа. Нийт арилжааны 59.1 хувийг 1/3 коксжих нүүрс, 17.2 хувийг дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрс, 8.3 хувийг баяжуулсан коксжих нүүрс, 4.6 хувийг баяжуулсан дунд зэрэг үнстэй, хагас хатуу коксжих нүүрс, 2.9 хувийг баяжуулсан сул коксжих нүүрс, 2.8 хувийг дэгдэмхий бодис дундаас их хийн нүүрс, 2.6 хувийг эрчим хүчний нүүрс, 2.1 хувийг баяжуулсан коксжих чанаргүй нүүрс, 0.3 хувийг чийг багатай хүрэн нүүрс, 0.1 хувийг дэгдэмхий бодис их, хийн нүүрс тус тус эзэлж байна.




ЗЭС БАЯЖМАЛЫН АРИЛЖАА

Нийт 16 багц буюу 16.0 мянган тонн 22.35%-ийн зэсийн агуулгатай баяжмалыг 160.2 тэрбум төгрөгөөр арилжлаа.


АШИГТ АЖИЛЛАГАА

ҮЦК /САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ/

- Тайлант улиралд ҮЦК-уудын нийт хөрөнгө 286.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 4.7 хувиар буурсан үзүүлэлт юм.
- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлого 18.1 тэрбум төгрөгөөр, зарлага 15.0 тэрбум төгрөгөөр өсөж 10.2 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.




ҮЦК-ИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ



ҮЦК-ИЙН ЗАРДЛЫН БҮТЭЦ

- Борлуулалтын маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардал
- Санхүүгийн зардал
- Бусад зардал
- Орлогын татварын зардал
- Гадаад валютын ханшийн зөрүүний гарз
- Бусад алдагдал



ҮЦК-УУДЫН УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР, НДШ




- Үнэт цаасны компаниуд НДШ-д 2.4 тэрбум төгрөг, ААН-ийн орлогын албан татварт 1.6 тэрбум төгрөг, ХХОАТ-т 0.7 тэрбум төгрөгийг тус тус төлж, улсын төсөвт нийт 4.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлээд байна.


ДОТООДЫН НОМИНАЛЬ ДАНСНЫ АРИЛЖААНЫ ТАЙЛАН

- Номиналь дансаар дамжуулан харилцагчдад үйлчилгээ үзүүлж байгаа 22 компанид бүртгэлтэй 1,408,510 харилцагч байгаагаас тайлант улиралд 23,967 харилцагч номиналь дансаар дамжуулан үйлчилгээ авсан байна.

ҮНЭТ ЦААСНЫ НОМИНАЛЬ ДАНСНЫ ХАРИЛЦАГЧИЙН ТОО




Тайлант улиралд нийт мөнгөн хөрөнгийн номиналь дансаар 366.4 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж номинал дансны нийт үлдэгдэл 40.7 тэрбум төгрөг байна. Үүнээс төгрөгийн номиналь дансаар 205.8 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж номинал дансны нийт үлдэгдэл 28.2 тэрбум төгрөг, гадаад валютын номиналь дансаар 160.6 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж номинал дансны нийт үлдэгдэл 12.5 тэрбум төгрөг байна.




ХОМК /САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ/

- ХОМК-уудын нийт хөрөнгө 118.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 23.6 хувиар буурсан үзүүлэлт юм.
- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлого 3.1 тэрбум төгрөгөөр, зарлага 1.6 тэрбум төгрөгөөр буурч 1.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан.




ХОМК-ИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ

- Үйл ажиллагааны орлого
- Ногдол ашгийн орлого
- Гадаад валютын ханшийн зөрүүний олз
- Хүүний орлого
- Бусад орлого



ХОМК-ИЙН ЗАРДЛЫН БҮТЭЦ




- Борлуулалтын маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардал
- Орлогын татварын зардал
- Бусад алдагдал
- Санхүүгийн зардал
- Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз
- Бусад олз



- ХОМК-ууд НДШ-д 0.9 тэрбум төгрөг, ХХОАТ-т 0.2 тэрбум төгрөг, ААН-ийн орлогын албан татварт 0.5 тэрбум төгрөгийг тус тус төлж, улсын төсөвт 1.5 тэрбум төгрөг төвлөрүүлсэн.


ХААБ /САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ/

- ХААБ-уудын нийт хөрөнгө 5.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 21.6 хувиар өссөн үзүүлэлт юм.
- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлого 0.6 тэрбум төгрөгөөр, зарлага 0.8 тэрбум төгрөгөөр буурч, 0.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.




КАСТОДИАН /САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ/

- Кастодиан банкны нийт хөрөнгө 6,643.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 40.1 хувиар өссөн үзүүлэлт юм.
- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлого 0.4 тэрбум төгрөгөөр өсөж, зарлага 0.2 тэрбум төгрөгөөр буурч, 0.7 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ.




КАСТОДИАНЫ ХАРИЛЦАГЧДЫН БҮТЭЦ

- Кастодиан банкны нийт харилцагчдын 91.5 хувийг дотоодын иргэн, 7.1 хувийг дотоодын ААН, 0.8 хувийг гадаадын иргэн, 0.6 хувийг гадаадын ААН тус тус эзэлж байна.




- Кастодиан банканд хадгалагдаж буй хөрөнгийг ангилан үзвэл 1.4 хувийг харилцагчдын эзэмшиж буй үнэт цаас, 98.6 хувийг ХБҮЦ тус тус эзэлж байна.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

- Зах зээлийн үнэлгээний 90.5 хувийг хамгийн өндөр үнэлгээтэй 20 компани, 79.7 хувийг хамгийн өндөр үнэлгээтэй 10 компани бүрдүүлж байна. Үүнээс үзэхэд зах зээл хэт төвлөрөлтэй байна.



ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХАМГИЙН ӨНДӨР 20 КОМПАНИ

№	Компанийн нэр	Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/	Нийт ЗЗҮ–д злэх хувь
1	ХААН БАНК ХК	2,799.5	20.5%
2	ТАВАН ТОЛГОЙ ХК	1,527.3	11.2%
3	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН ХК	1,194.1	8.7%
4	ХАС БАНК ХК	1,128.8	8.3%
5	ГОЛОМТ БАНК ХК	1,044.8	7.6%
6	АПУ ХК	1,000.3	7.3%
7	ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК	860.2	6.3%
8	ИНВЕСКОР ББСБ ХК	684.0	5.0%
9	ТӨРИЙН БАНК ХК	356.6	2.6%
10	МИК ХОЛДИНГ ХК	320.6	2.3%
11	ПРЕМИУМ НЭКСУС ХК	295.3	2.2%
12	СҮҮ ХК	205.2	1.5%
13	ГОВЬ ХК	173.2	1.3%
14	ТАНДЭМ ИНВЕСТ ББСБ ХК	157.3	1.1%
15	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК	119.7	0.9%
16	МОНГОЛ ДААТГАЛ ХК	115.2	0.8%
17	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК	111.4	0.8%
18	ЛЭНДМН ББСБ ХК	109.6	0.8%
19	ГУТАЛ ХК	94.5	0.7%
20	ЭМ ЖИ ЭЛ АКУА ХК	85.2	0.6%

ХУВЬЦААНЫ ТӨВЛӨРӨЛ

Монголын хөрөнгийн бирж (МХБ), Улаанбаатар үнэт цаасны бирж (УБҮЦБ)-д бүртгэлтэй 164 ХК-ийн хувьцааны төвлөрлийг 5-аас дээш болон түүнээс доош хувь эзэмшдэг хувьцаа эзэмшигчийн тоогоор доор хүснэгтэд харуулав.


	Эзэмшлийн хувь	5-аас их хувь		Эзэмшлийн хувь	5-аас бага хувь
	20%–50%	5		50%–70%	4
	51%–70%	18		30%–49%	17
	71%–90%	84		10%–29%	79
	91%–100%	57		0%–9%	64

Эдгээр 164 ХК-ийн хувьцааны эзэмшил өндөр төвлөрсөн бүтэцтэй байна. Тухайлбал, 5-аас их хувийн эзэмшилтэй 71–90 хувийн эзэмшилтэй 84, 91–100 хувийн эзэмшилтэй 57 компани байгаа нь компаниудын хувьцааны дийлэнх хэсгийг цөөн тооны хувьцаа эзэмшигч эзэмшиж байгааг илтгэж байна. Харин 5-аас бага хувийн эзэмшилтэй хувьцаа эзэмшигчдийн хувьд 0–29 хувийн эзэмшилтэй 79, 0–9 хувийн эзэмшилтэй 64 компани байгаа нь жижиг хувьцаа эзэмшигчдийн оролцоо харьцангуй сул байгааг харуулж байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨВЛӨРӨЛ

Хувьцааны зах зээлийн төвлөрлийг Hirschman–Herfindahl Index-ээр тооцов. 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар зах зээлийн үнэлгээний 79.0 хувийг ТОП-20 индексийн сагсанд багтах компаниуд бүрдүүлж байна. Үүнээс банк, санхүүгийн салбар 66.7 хувийг, бусад салбар 33.7 хувийг тус тус эзэлж байна.

ННІ ИНДЕКС



2026 оны 1 дүгээр улирлын байдлаар ННІ индекс 2500-аас дээш буюу 3,908 байгаа нь зах зээлийн төвлөрөл маш өндөр байгааг харуулж байна.

ННІ индексийн тайлбар:

- 100-аас доош байгаа тохиолдолд зах зээл огт төвлөрөлгүй;
- 100–1500-ын хооронд байвал зах зээл төвлөрөл багатай;
- 1500–2500 хооронд байвал зах зээл төвлөрөлтэй;
- 2500-аас дээш бол маш өндөр төвлөрөлтэй.

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН



Монгол Улсын Их Хурлаас 2025 онд “Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” 79 дүгээр тогтоолыг баталсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо дотоодын аж ахуйн нэгжүүд болон мэргэжлийн оролцогчдын хөрөнгийн зах зээлд оролцох зардлын ачааллыг бууруулж, үнэт цаас гаргах замаар санхүүжилт татах боломжийг нэмэгдүүлэх бодлогын шийдвэр гаргаж, зохицуулалтын үйлчилгээний хөлсийг хувьцаанаас бусад үнэт цаасны арилжааны хэлцэл тус бүрийн хувьд 100 хувиар, арилжааны хэлцэл тус бүрийн хувьд 50 хувиар, мөн үнэт цаасны арилжаа эрхлэх этгээдүүдийн шимтгэлийн орлогын хувьд 50 хувиар тус тус буурууллаа.

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг дунд болон урт хугацаанд тогтвортой, үе шаттайгаар хөгжүүлэх, зах зээлийн үр ашиг, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хороо Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК)-тай хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр байгууллаа. Тус санамж бичгээр хоёр тал хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, олон улсын жишиг болон ижил түвшний болон хөгжингүй зах зээлүүдтэй харьцуулсан үнэлгээ гаргана. Мөн өмнө хэрэгжүүлсэн бодлого, шинэчлэлийн үр нөлөөг үнэлж, цаашдын хөгжлийн тэргүүлэх чиглэл, бодлогын хэрэгжилтийн замын зураглалыг тодорхойлох юм.

ХАМТЫН АЖИЛЛАГАА



Санхүүгийн зохицуулах хорооноос Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, олон улсын зах зээлд сурталчлах, гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх, дотоодын компаниудад олон улсын зах зээлээс санхүүжилт татах боломжийг сайжруулах зорилгоор “Монголын хөрөнгийн зах зээлийг холбох нь” цуврал арга хэмжээг 2026 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр БНХАУ-ын Бээжин хотод зохион байгуулж, Монголын хөрөнгийн зах зээл, уул уурхайн салбарыг БНХАУ-ын эх газрын мужуудад таниулан сурталчлах, хоёр улсын хөрөнгийн биржүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, дотоодын компаниудыг БНХАУ-ын биржүүдэд давхар бүртгүүлэх, хадгаламжийн сертификат гаргахад дэмжлэг үзүүлэх, гадаадын томоохон хөрөнгө оруулагчдын сонирхол, оролцоог нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан арга хэмжээ боллоо.

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ



ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

Нийт хөрөнгө

804.1 тэрбум
төгрөг

Хөрөнгийн өсөлт 19.0%



ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

Даатгалын үнэлгээ

148.3 их наяд



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

Даатгалын бүтээгдэхүүний тоо

114



АШИГТ
АЖИЛЛАГАА

Цэвэр ашиг
10.2 тэрбум
төгрөг



ТОГТВОРТОЙ
БАЙДАЛ

Гадаад улсад төвлөрүүлсэн давхар
даатгалын хураамжийн зардал

29.7%



БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТ

ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ


ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН БҮТЭЦ

2026 оны 1 дүгээр улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн үндсэн дээр нийт 1153 хувь хүн /актуарч, даатгалын төлөөлөгч/ болон 166 хуулийн этгээд /даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч, аудитын компани/ үйл ажиллагаа эрхэлж байна.




ДААТГАЛЫН ГҮНЗГИЙРЭЛТ

Гүнзгийрэлт 0.48 хувьд хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1 пунктээр буурч, 2022 оны мөн үетэй харьцуулахад 0.06 пунктээр буурсан байна.




ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ТОО

Нийт 720,473 даатгалын гэрээний 631,860 буюу 87.7 хувийг хувь хүнтэй, 88,613 буюу 12.3 хувийг хуулийн этгээдтэй байгуулсан болно.




Ердийн даатгалын гэрээний төрөл

- Гэнэтийн осол, эмчилгээний даатгал
- Авто тээврийн хэрэгслийн даатгал
- Жолоочийн хариуцлагын даатгал
- Хөрөнгийн даатгал
- Хариуцлагын даатгал
- Бусад




Урт хугацааны даатгалын гэрээний төрөл



- Хугацаат амьдралын даатгал
- Эрүүл мэндийн даатгал
- Бусад

ХУВЬ ХҮНТЭЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ХҮЙСИЙН ХАРЬЦАА /ХУВИАР/



НӨХӨН ТӨЛБӨР АВСАН ДААТГУУЛАГЧИЙН ТОО

Тайлант улиралд нөхөн төлбөр авсан 878 даатгуулагчийн 827 буюу 94.2 хувь нь хувь хүн, 51 буюу 5.8 хувь нь хуулийн этгээд байна.

Хуулийн
этгээд

51


827
Хувь хүн

НӨХӨН ТӨЛБӨР АВСАН ДААТГУУЛАГЧИЙН ХҮЙСИЙН ХАРЬЦАА /ХУВИАР/



ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН НИЙТ ХӨРӨНГӨ


- Нийт хөрөнгийн хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19.0 хувиар өсөж 804.1 тэрбум төгрөгт хүрсэн бол 2022 оны мөн үетэй харьцуулахад 92.2 хувиар өсжээ.
- Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 18.7 хувиар, урт хугацааны даатгалын компаниудын хувьд 74.3 хувиар, давхар даатгалын компанийн хувьд 7.0 хувиар тус тус өссөн байна.
- Харин нийт хөрөнгийн хэмжээгээр ердийн даатгалын компаниуд 87.2 хувь, давхар даатгалын компаниуд 8.8 хувь, урт хугацааны даатгалын компаниуд 4.0 хувийг тус тус эзэлж байна.



ЗАХ ЗЭЭЛИЙН БҮТЭЦ

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн бүтцийг авч үзвэл 470.2 тэрбум төгрөг буюу 58.5 хувийг хөрөнгө оруулалт, 62.6 тэрбум төгрөг буюу 7.8 хувийг үндсэн ба биет бус хөрөнгө /цэвэр дүн/, 34.0 тэрбум төгрөг буюу 4.2 хувийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, 237.3 тэрбум төгрөг буюу 29.5 хувийг бусад хөрөнгө тус тус бүрдүүлж байна.


- Даатгалын компаниудыг нийт хөрөнгөд эзэлж буй хувиар нь авч үзвэл 9 хувиас дээш хувийг 2 даатгалын, 6–9 хувийг 6 даатгалын, 3–6 хувийг 4 даатгалын, 3 хувиас доош хувийг 10 даатгалын компани бүрдүүлж байна.



■ Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө ■ Хөрөнгө оруулалт
■ Үндсэн ба биет бус хөрөнгө ■ Бусад хөрөнгө

ДААТГАЛЫН БОЛОН ДАВХАР ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН ХӨРӨНГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ

2025.I / 2026.I



ДААТГАЛЫН КОМПАНИЙН ХӨРӨНГИЙН ӨСӨЛТИЙН ТАРХАЛТ

- Хөрөнгийн өсөлтөөр нь бүлэглэвэл 30 хувиас дээш өсөлттэй 6, 20–30 хувийн өсөлттэй 4, 10–20 хувийн өсөлттэй 2, 10 хувиас доош өсөлттэй 7, хөрөнгийн хэмжээ буурсан 1 даатгалын компани байна.
- Коннект лайф урт хугацааны даатгалын компани нь 2025 оны 3 дугаар улиралд, Үндэстэн Женерал даатгалын компани 2025 оны 4 дүгээр улиралд үйл ажиллагаа явуулж эхэлсэн тул хөрөнгийн өсөлтийг тооцоогүй болно.

2024.I–2025.I / 2025.I–2026.I




ЭЗДИЙН ӨМЧИЙН БҮТЭЦ /ТЭРБҮМ ТӨГРӨГ/

Эздийн өмч	Ердийн даатгал	Урт хугацааны даатгал	Давхар даатгал
Эзэмшигчдийн өмч	110.9	19.3	24.5
Халаасны хувьцаа	(2.6)	–	–
Нэмж төлөгдсөн капитал	18.0	–	–
Тогтвортой байдлын нөөц сан	3.3	–	–
Хөрөнгийн дахин үнэлгээний өөрчлөлт	18.1	0.4	–
Гадаад валютын хөрвүүлгийн нөөц	–	–	–
Эздийн өмчийн бусад хэсэг	1.3	–	4.2
Хуримтлагдсан ашиг, алдагдал	118.9	(0.6)	4.3
Эздийн өмчийн дүн	267.9	19.1	33.0


НИЙТ ХУРААМЖ

- Тайлант улиралд ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд нийт 140.2 тэрбум төгрөгийн даатгалын хураамж бүрдүүлснээс ердийн даатгалын компаниуд 137.0 тэрбум төгрөг буюу 97.7 хувь, урт хугацааны даатгалын компаниуд 3.2 тэрбум төгрөг буюу 2.3 хувийг эзэлж байна.
- Давхар даатгалын хураамжид 44.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлснээс 3.1 тэрбум төгрөг буюу 7.0 хувийг дотоодын давхар даатгагчид төлсөн.
- Нийт хураамжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29.8 хувь, 2022 оны мөн үетэй харьцуулахад 2.8 дахин өсжээ.




НИЙТ НӨХӨН ТӨЛБӨР

- Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 47.9 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5 хувиар буурсан бол 2022 оны мөн үетэй харьцуулахад 1.8 дахин өсжээ.
- Нийт нөхөн төлбөрийн зардлын 46.7 тэрбум төгрөг буюу 97.4 хувийг ердийн даатгалын компани эзэлж байна.
- Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрийн дүн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 75.2 хувиар буурч 2.8 тэрбум төгрөгт хүрсэн байна.




ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО, НӨХӨН ТӨЛБӨРИЙН ЭЗЛЭХ ХУВЬ /ДААТГАЛЫН ХЭЛБЭРЭЭР/



НӨӨЦ САН


Даатгалын салбарын нийт нөөц сангийн хэмжээ 370.2 тэрбум төгрөгт хүрлээ.

Ердийн даатгалын компаниудын нийт нөөц сангийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.3 хувиар өсөж 326.4 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын компаниудын нөөц сан 46.8 хувиар өсөж 7.7 тэрбум төгрөг, давхар даатгалын компанийн нөөц сан 22.7 хувиар өсөж 36.1 тэрбум төгрөгт хүрлээ.



ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

- Даатгалын салбарын өөрийн хөрөнгийг 2022 оны мөн үетэй харьцуулахад 57.3 хувиар, өмнөх оны мөн үеэс 15.7 хувиар өсөж 320.0 тэрбумд хүрлээ.
- Үүнээс 83.7 хувийг ердийн даатгалын компаниуд, 6.0 хувийг урт хугацааны даатгалын компаниуд, 10.3 хувийг давхар даатгалын компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ эзэлж байна.




ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ


Тайлант улиралд даатгалын компаниуд 148.3 их наяд төгрөгийн үнэлгээ бүхий даатгалын эрсдэлийг хүлээн авсан байна.

Даатгалын үйлчилгээний хүртээмжийг даатгалын компанийн салбар нэгжүүд, мэргэжлийн оролцогчдын тоо болон цахим үйлчилгээний хөгжлийн түвшнээр илэрхийлэх боломжтой юм. Улаанбаатар хотод нийт 483, орон нутагт нийт 635 даатгалын төлөөлөгч үйл ажиллагаа явуулж байна.

ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИД



Орон нутагт даатгалын компанийн 195, даатгалын зуучлагч компанийн 200 болон хохирол үнэлэгч компанийн 49 нийт 444 салбар үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрээс төвийн бүсэд даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлгээний салбарууд хамгийн их төвлөрсөн байна.



Улаанбаатар хотод 253 салбар үйл ажиллагаа явуулсан ба үүнээс даатгалын компанийн 36, даатгалын зуучлагчийн 228, хохирол үнэлэгчийн 45 салбар байна. Эдгээрийг дүүргээр ангилан үзвэл салбар нэгжийн 92.9 хувь нь төвийн 6 дүүрэгт төвлөрчээ.




	СОНГИНО ХАЙРХАН	ЧИНГЭЛТЭЙ	СҮХБААТАР
Компаниудын салбар	3	5	8
Зуучлагчдын салбар	19	37	48
Хохирол үнэлэгчдийн албар	10	4	8
	ХАН – УУЛ	БАЯНГОЛ	БАЯНЗҮРХ
Компаниудын салбар	2	4	3
Зуучлагчдын салбар	39	34	41
Хохирол үнэлэгчдийн албар	5	7	10
	НАЛАЙХ	БАГАНУУР	БАГАХАНГАЙ
Компаниудын салбар	3	7	1
Зуучлагчдын салбар	6	4	0
Хохирол үнэлэгчдийн албар	0	1	0

Даатгалын компанийн 12 төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнээс БНХАУ, БНСУ–д тус тус нэг байна.

ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ


2026 оны 1 дүгээр улирлын байдлаар даатгалын салбарт цахим сувгаар үйл ажиллагаа явуулж буй компаниудын хувьд 25 хувь аппликейшн, 50 хувь цахим хуудас, 18.9 хувь чатбот, 6.1 хувийг бусад цахим үйлчилгээ ашиглаж байна.



БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ



Давхардсан даатгалын бүтээгдэхүүн тоо




Ердийн болон урт хугацааны даатгалын 23 хэлбэрээс “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал”-аас бусад нь сайн дурын даатгалын хэлбэр юм.

2026 оны 1 дүгээр улирлаас эхлэн даатгалын бүтээгдэхүүний тоог давхардаагүй байдлаар тооцож эхэлсэн бөгөөд нийт 114 бүтээгдэхүүн бүртгэгдээд байна.

ДААТГАЛЫН НЯГТРАЛ


Даатгалын нягтрал /төгрөгөөр/



- Даатгалын нягтрал 2025 онд 163,223 төгрөг болж 2024 онтой харьцуулахад 15.1 хувиар, 2021 онтой харьцуулахад 1.2 дахин тус тус өссөн байна.
- Даатгалын нягтралыг авч үзвэл, нэг хүнд ногдох ердийн даатгалын хураамж 14.4 хувиар өсөж 163,223 төгрөгт хүрсэн бол урт хугацааны даатгалын хураамж 93.5 хувиар өсөж 2,470 төгрөгт тус тус хүрсэн байна.


АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нийт хураамж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.5 хувиар өсөж 14.8 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт даатгалын хураамжийн орлогын 10.5 хувийг эзэлж байна.
- Олгосон нөхөн төлбөр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.8 хувийн өсөлттэй бөгөөд 15.8 тэрбум төгрөгт хүрсэн нь салбарын нийт нөхөн төлбөрийн зардлын 32.9 хувийг эзэлж байна.




ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧИД

- Даатгалын зуучлагчдын төвлөрүүлсэн даатгалын болон давхар даатгалын хураамж 38.1 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин даатгалын зуучлагчдын зуучлалын шимтгэлийн орлого өмнөх оны мөн үед 7.0 тэрбум төгрөг байснаас 19.4 хувиар өсөж 8.3 тэрбум төгрөгт хүрэв.




ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧИД

- Даатгалын хохирол үнэлэгч компаниуд нийт 11,237 хохирлыг 42.0 тэрбум төгрөгөөр үнэлэв. Нийт даатгалын хохирол үнэлгээний орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.6 хувиар өсөж 1.7 тэрбум төгрөгт хүрлээ.



АШИГТ АЖИЛЛАГАА

- Даатгалын компаниудын цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 29.6 хувиар буурч 10.2 тэрбум төгрөгт хүрсэн. Харин 2022 оны мөн үетэй харьцуулахад 3.0 дахин өссөн байна. 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар 16 даатгалын компани ашигтай ажилласан бол 6 компани алдагдалтай ажилласан байна.
- Татварын дараах цэвэр ашгийн өсөлтийг ашигтай ажилласан 14 компанийн хувьд авч үзвэл цэвэр ашгийн хэмжээ буурсан 3, 50 хувь хүртэлх өсөлттэй 4, 50–100 хувь хүртэлх өсөлттэй 1, 100 хувиас дээш өсөлттэй 6 компани байна.




Даатгалын компанийн орлогын бүтэц

Нийт орлогын бүтэц	Дүн /тэрбум төг/
Даатгалын нийт хураам- жийн орлого	143.4
Бусад орлого	19.7

Даатгалын компанийн зардлын бүтэц


Нийт орлогын бүтэц	Дүн /тэрбум төг/
Даатгалын хураамжийн буцаалт	3.6
Давхар даатгалын хураамж	46.4
Даатгалын нөөц сангийн зардал	3.3
Даатгагчаас олгосон нөхөн төлбөр	44.8
Даатгалын гэрээний зардал	14.9
Үйл ажиллагааны зардал	38.0
Орлогын албан татварын зардал	1.8

ГОЛЛОХ ХАРЬЦААНУУД



АШИГТ АЖИЛЛАГААНЫ КОЭФФИЦИЕНТ

- Нийт хөрөнгийн өгөөж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.9 пунктээр буурч 1.3 хувьд хүрсэн бол өөрийн хөрөнгийн өгөөж 1.9 пунктээр буурч 3.4 хувьд хүрэв.



Даатгалын компаниуд 3.0 тэрбум төгрөгийг НДШ-д, 1.2 тэрбум төгрөгийг ААНОАТ-т, 1.8 тэрбум төгрөгийг ХХОАТ-т төлж нийт 6.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.


ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ


- Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд нийт 44.8 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийн 3.1 тэрбум төгрөгийг дотоодын давхар даатгагчдад, үлдсэн 41.6 тэрбум төгрөгийг олон улсын давхар даатгалын компаниудад шилжүүлсэн.
- Даатгалын компаниудын гадаад улсад төвлөрүүлсэн давхар даатгалын хураамжийн зардал даатгалын нийт хураамжийн 29.7 хувьтай тэнцэж байна.
- Монгол Улсын даатгалын зах зээлийн тулгамдаж буй асуудлын нэг нь валютын ханшийн эрсдэл юм.

Гадаад улсад төвлөрүүлсэн
давхар даатгалын
хураамжийн зардал

29.7%




Хөрөнгийн зах зээл буюу үнэт цаас болон деривативт оруулсан хөрөнгө оруулалтын дүн 82.3 тэрбум төгрөг болсон нь нийт хөрөнгө оруулалтын 17.5 хувийг эзэлж байна. Харин банкны салбарт байршуулсан хөрөнгө оруулалт 386.5 тэрбум төгрөг буюу 82.2 хувьд хүрлээ.



ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ

Даатгалын компаниудын үнэт цаасны зах зээлд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оны мөн үеэс 9.6 хувиар буурсан бол хадгаламж, хадгаламжийн сертификат буюу банкны салбарт оруулсан хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 20.8 хувиар өссөн байна.



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА



2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Дэлхийн банкны гамшгийн эрсдэлийн менежмент, бэлэн байдлыг сайжруулах төслийн хүрээнд зөвлөх багийн гишүүдтэй уулзалт хийж даатгалын салбарын өнөөгийн нөхцөл байдал, цаашид энэ чиглэлээр хамтран ажиллах боломжийн талаар санал солилцсон. Үүний үр дүнд зөвлөх багтай хамтран гамшгийн эрсдэлийн даатгалыг хөгжүүлэх хүрээнд хамтран ажиллахаар тохиролцсон бөгөөд 2026 оны 2–3 саруудад нийт 5 удаагийн уулзалтыг хийж төслийн ерөнхий бүрэлдэхүүн хэсгүүд болон хэрэгжүүлэх арга замын талаар хэлэлцээд байна.

Азийн хөгжлийн банкны ТА 10578-REG: “Гамшгийн эрсдэлийн менежментийг хөгжүүлэх төлөвлөгөө 2024–2030”-ыг хэрэгжүүлэх, гамшгийн эрсдэлийн санхүүжилтийн нөхцөл байдлыг судлах төслийн хүрээнд тус банкны зөвлөх багийг хүлээн авч, уулзалт хийсэн. 2026 оны 02 дугаар сарын 26-ны өдөр болсон тус уулзалтаар АХБ-ны өмнө хэрэгжүүлсэн төслийн үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл авахын зэрэгцээ даатгалын салбарын нөхцөл байдал, гамшгийн эрсдэлийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэх боломжтой ажлуудын талаар санал солилцсон.

2026 оны 3 дугаар сарын 04-ний өдөр Азийн хөгжлийн банкнаас CAREC /Төв Азийн бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага/-ыг хариуцан ажиллаж буй төслийн багтай цахим уулзалт хийсэн. Тус уулзалтаар АХБ-аас Төв Азийн бүс нутагт хэрэгжүүлж буй гамшгийн эрсдэлийн даатгалтай холбоотой үйл ажиллагааны талаар мэдээлэл авч, цаашдаа Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс энэ чиглэлээр хамтран ажиллах сонирхолтой байгааг мэдэгдэж ажилласан.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН



Даатгалын багц дүрмийн 1 дүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-д даатгалын нөхөн төлбөр олголт, мэдээллийн ил тод байдлыг сайжруулахтай холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулахаар журмын төслийг боловсруулж, олон нийтээс санал авахаар Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудсанд 2026 оны 03 дугаар сарын 22-ны өдөр байршуулсан.

УИХ-д Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг өргөн барьсантай холбогдуулан шаардлагатай тоо, мэдээллээр холбогдох талуудыг ханган ажиллаж байна. Мөн хуулийн төсөлд тусгагдсан Санхүүгийн зохицуулах хорооноос батлахаар заасан журмуудын хамрах хүрээ, зохицуулах харилцааг тодорхойлж, журмын төслийг боловсруулж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2026 оны 39 дүгээр тушаалаар байгуулсан зохицуулалттай этгээдийн санхүүгийн тайлагнал, аудитын үйл ажиллагаа болон түүний ил тод байдлыг сайжруулах санал боловсруулах ажлын хэсэгт Даатгалын газрын төлөөлөл ажиллаж, Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 104 дүгээр тогтоолоор Даатгалын багц дүрэмд, 105 дугаар тогтоолоор “Албан журмын даатгагчдын холбооны санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам”-д тус тус холбогдох өөрчлөлтийг оруулсан.

Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 5/11 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Малын индексжүүлсэн даатгалын хамтын эрсдэлийн сангийн хөрөнгө, түүнийг санхүүжүүлэх, зарцуулах журам”-тай холбогдуулан нэр бүхий даатгалын компаниас Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлтэй холбогдох тайлбар, нотлох баримтыг бүрдүүлж, шүүхэд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханы санаачилсан Эрүүл мэндийн ажилтны тухай хуулийн төсөлд эрүүл мэндийн салбарт эрсдэлийн удирдлага, хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэхэд даатгалын салбарын оролцоог нэмэгдүүлэх асуудлыг тусгах хүрээнд гишүүний ажлын алба болон Эрүүл мэндийн яамны төлөөлөлтэй хамтран ажиллаж, Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 1/551 тоот албан бичгээр санал хүргүүлсэн. Хуулийн төсөлд олон нийтээс санал авахаар d.parliament.mn-д байршуулсан.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдоос 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн УИХ-03/1863 тоот албан бичгээр ирүүлсэн газар тариалангийн даатгалын талаар мэдээлэл авах тухай албан бичигт хариу саналаа хүргүүлсэн бөгөөд 2026 оны 03 дугаар сарын 10-ны өдөр хуулийн төслийн анхны хэлэлцүүлэгт оролцож мэдээлэл солилцсон.

ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ



Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 199 дүгээр тушаалаар Даатгалын бодлогын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Даатгалын бодлогын зөвлөлд 4 удаа хуралдаж, 1 удаагийн зөвлөмж гаргасан. Уг зөвлөмжид даатгалын компаниудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх, даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны

зохицуулалтыг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авах, даатгалын компаниуд өөрсдийн эрсдэлийн удирдлагаа сайжруулах, олон нийтийг ил тод мэдээллээр хангаж ажиллах зэрэг агуулгыг тусгасан. Түүнчлэн даатгалын салбарын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон даатгалын салбарын хууль эрх зүйн орчны шинэчлэл, урт хугацааны даатгал, давхар даатгалын тогтолцоог хөгжүүлэх арга зам, даатгалын хохирол үнэлэгч, хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа, тулгамдсан асуудлуудын талаар Даатгалын бодлогын зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцэв.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА



ЗАХ ЗЭЭЛИЙН
ТӨЛӨВ

Нийт хөрөнгө

9.6 тэрбум
төгрөг

Хөрөнгийн өсөлт **26.5%**



ХҮРТЭЭМЖТЭЙ
БАЙДАЛ

Дундаж зээлийн хэмжээ

2.2 сая
төгрөг

Харилцагч

4.3 сая



БҮТЭЭГДЭХҮҮН
ҮЙЛЧИЛГЭЭ

88.9% Зээлийн ББСБ

Зөвхөн гадаад валют
арилжааны ББСБ **11.1%**



АШИГТ
АЖИЛЛАГАА

Нийт орлого

772.1 тэрбум
төгрөг

Улсад татан төвлөрүүлсэн
татвар, НДШ

51.9 тэрбум
төгрөг

Z индекс
15.4



ТОГТВОРТОЙ
БАЙДАЛ

Чанаргүй зээлийн эзлэх хувь


8.9%



БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТ

ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ


Улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын тоо өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар нэмэгджээ.




ББСБ-уудын 4.5 хувь нь гадаадын, 95.5 хувь нь үндэсний хөрөнгө оруулалттай болно.

26 ББСБ гадаадын
хөрөнгө оруулалттай

ХАРИЛЦАГЧДЫН ТОО



ЗЭЭЛДЭГЧДИЙН ТОО




Өмнөх оны мөн үеэс ББСБ-уудын харилцагчдын тоо 16.3 хувиар, зээлдэгчдийн тоо 34.3 хувиар тус тус өссөн.

Нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2,002.5 тэрбум төгрөгөөр буюу 26.5 хувиар өссөн бөгөөд 2022 оны мөн үеэс 3.2 дахин нэмэгдсэн байна.

26.5%
Хөрөнгийн өсөлт

72.0%
Зээлийн өсөлтийн нөлөө

НИЙТ ХӨРӨНГӨ /тэрбум төгрөг/



ББСБ-уудын активын бүтэц /тэрбум төгрөгөөр/


САНХҮҮГИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,111.0	95.2%	
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,005.3	10.5%	
Хөрөнгө оруулалт	143.6	1.5%	
Зээл /цэврээр/	7,619.8	79.6%	
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	103.8	1.1%	
Үүсмэл санхүүгийн хөрөнгө	3.3	0.0%	
Бусад санхүүгийн хөрөнгө	235.2	2.5%	
САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	459.9	4.8%	
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,570.9	100.0%	

- ББСБ-ын салбарын нийт хөрөнгийг өмнөх оны мөн үеэс 26.5 хувиар өсөхөд зээлийн 72.0 хувийн өсөлт нөлөөлжээ.

ББСБ-уудын пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/

НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	4,435.8	46.4%	
САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	4,200.2	43.9%	
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	1,585.5	16.6%	
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	1,480.5	15.5%	
Бусад эх үүсвэр	712.8	7.4%	
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	2.1	0.0%	
Бусад санхүүгийн өр төлбөр	331.9	3.5%	
Хоёрдогч өглөг	86.1	0.9%	
Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	1.3	0.0%	
САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	235.6	2.5%	
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,135.1	53.6%	
Хувь нийлүүлсэн хөрөнгө	2,333.8	24.4%	
Нэмж төлөгдсөн капитал	109.0	1.1%	
Халаасны хувьцаа	2.6	0.0%	
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	22.8	0.2%	
Хуримтлагдсан ашиг, алдагдал	2,517.6	26.3%	
Бусад өмч	154.5	1.6%	
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,570.9	100.0%	

- Салбарын эх үүсвэрийн бүтцийн 46.4 хувь нь өр төлбөр, 53.6 хувь нь өөрийн хөрөнгө болно.
- Өмнөх оны мөн үеэс итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр 32.6 хувиар, банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 4.0 хувиар өсөж ББСБ-аас гаргасан өрийн бичиг 3.5 хувиар буурсан байна




Салбар	ББСБ–ын тоо		Нийт хөрөнгө		Нийт зээл		Зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн эзлэх хувь	Харилцагчдын тоо	
	Тоо	%	Хэмжээ /тэрбум төг/	%	Хэмжээ /тэрбум төг/	%		Тоо	%
25 %	4	0.7%	2,266.9	23.7%	1,950.9	25.1%	2.5%	721,808	16.6%
50 %	13	2.2%	4,704.6	49.2%	3,987.7	51.3%	4.6%	2,538,892	58.4%
75 %	58	10.0%	7,176.4	75.0%	6,111.0	74.7%	6.8%	3,821,604	87.9%
НИЙТ	578	100.0%	9,570.9	100.0%	7,767.3	100.0%	8.9%	4,347,995	100.0%

Салбарын нийт хөрөнгийн 75 хувийг бүрдүүлж буй ББСБ–ын зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь нь нийт зээлийн дунджаас доогуур байна.


	ББСБ– ын тоо	Нийт хөрөнгө		Нийт зээл		Харилцагчдын тоо	
		Хэмжээ /тэрбум төг/	%	Хэмжээ /тэрбум төг/	%	Тоо	%
Дотоодын хөрөнгө оруулалттай	552	8,547.8	89.3%	6,979.8	89.9%	4,235,005	97.4%
Гадаадын хөрөнгө оруулалттай	26	1,023.1	10.7%	787.5	10.1%	112,990	2.6%

Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ–уудын 46.2 хувь буюу 12 нь Япон, 23.1 хувь буюу 6 нь БНСУ, 11.5 хувь буюу 3 нь БНХАУ–ын, харин үлдсэн нь Канад, Малайз, Сичелл зэрэг бусад улсын хөрөнгө оруулалттай байна.




НИЙТ ЗЭЭЛ /тэрбум төгрөг/

Салбарын нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 22.8 хувиар буюу 1.4 их наяд төгрөгөөр, 2022 оны мөн үеэс 3.4 дахин буюу 5.5 их наяд төгрөгөөр өсжээ.



НИЙТ ЗЭЭЛИЙН БҮТЭЦ



ЖИГНЭСЭН ДУНДАЖ ХҮҮ



3.6%

ББСБ-ын салбарын
жигнэсэн дундаж хүү



2.9%

Уламжлалт зээлийн
жигнэсэн дундаж хүү



4.1%

Финтек зээлийн
жигнэсэн дундаж хүү

4.0 их наяд төг | Олгосон зээл

Төлөгдсөн зээл | 3.5 их наяд төг

Бөөний болон жижиглэн
худалдаа



7.1%

6.4%

Барилга



2.6%

2.2%

Тээвэр, агуулахын үйл
ажиллагаа



1.3%

1.4%

Санхүүгийн болон
даатгалын үйл ажиллагаа



2.3%

2.2%

Үл хөдлөх
хөрөнгийн
үйл
ажиллагаа



1.0%

0.9%

Зочид буудал,
байр, сууц
болон нийтийн
хоолны
үйлчилгээ



0.6%

1.0%

Хөдөө аж
ахуй, ойн аж
ахуй, загас
барилт, ан
агнуур



0.6%

0.6%

Бусад



84.5%

85.3%



ИРГЭН



ХУУЛИЙН ЭТГЭЭД

88.3%

6,861.2

Зээлийн үлдэгдэл

11.7%

906.1

90.4%

3,660.6

Олгосон зээл

9.6%

387.3

91.2%

3,183.8


Төлөгдсөн зээл

8.8%

307.6

ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛ


ОЛГОСОН ЗЭЭЛ



2,257.1 тэрбум төгрөг

Олгосон болон
төлөгдсөн зээлийн
50-аас дээш
хувийг хэрэглээний
зээл эзэлж
байна.

ТӨЛӨГДСӨН ЗЭЭЛ



2,106.0 тэрбум төгрөг



ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛ



АВТОМАШИНЫ ЗЭЭЛ

Зээлийн үлдэгдэл


2026.I	3,862.9 тэрбум төгрөг	↑ +1.2%
2025.I	3,815.5 тэрбум төгрөг	

2026.I	1,336.0 тэрбум төгрөг	↓ -19.0%
2025.I	1,650.1 тэрбум төгрөг	

Олгосон зээл

2026.I	2,257.1 тэрбум төгрөг	↓ -13.4%
2025.I	2,605.8 тэрбум төгрөг	



2026.I	169.9 тэрбум төгрөг	↓ -60.6%
2025.I	431.0 тэрбум төгрөг	



Олгосон зээлийн хамгийн өндөр хувийг 1 сар хүртэлх болон 1-2.5 жилийн хугацаатай зээлүүд эзэлж байна.

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ


Улсын хэмжээнд 578 ББСБ болон тэдгээрийн 603 (Австрали улсад 1) салбар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна. ББСБ-уудын байршлыг зураглалаар харвал дийлэнх буюу 82.7 хувь нь Улаанбаатар хотод байршиж байна.



Олон улсын санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ийн боловсруулсан индикаторуудыг ашиглан ББСБ-ын салбарын хүртээмжийг тооцвол:

12 аймагт 3 буюу түүнээс дээш тооны ББСБ ажиллаж байгаа нь нийт ББСБ-ын салбарын 57.1 хувийг бүрдүүлж байна.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй 478 ББСБ-ын 34.1 хувь нь Сүхбаатар, 25.5 хувь нь Чингэлтэй, 13.4 хувь нь Баянгол, 13.2 хувь нь Хан-Уул, 11.9 хувь нь Баянзүрх, 1.7 хувь нь Сонгинохайрхан, 0.2 хувь нь Багануур дүүрэгт тус тус байршиж байна.




ББСБ-уудын хүртээмж, газар зүйн байршлаар:

- Монгол Улсын хэмжээнд 18–64 насны 100,000 иргэнд 60.2 ББСБ, 1,000 аж ахуйн нэгжид 10.1 ББСБ ногдож байна.
- Орон нутгийн хэмжээнд эдгээр үзүүлэлтүүд харгалзан 34.6 болон 9.9 байгаа бөгөөд бүс нутгийн хувьд Төвийн бүс 100,000 иргэнд 49.2 ББСБ, 1,000 аж ахуйн нэгжид 12.7 ББСБ ногдох үзүүлэлтээр тэргүүлж байна.
- Улаанбаатар хотод 100,000 иргэнд 87.4 ББСБ, 1,000 аж ахуйн нэгжид 10.2 ББСБ ногдож байгаа нь орон нутгийн үзүүлэлтээс харьцангуй өндөр буюу хүртээмж илүү байна.




- Монгол Улсын хэмжээнд ББСБ-аас нэг зээлдэгч дунджаар 2.2 сая төгрөгийн зээл авсан бол орон нутагт энэ үзүүлэлт 1.9 сая төгрөг, Улаанбаатар хотод 2.3 сая төгрөг байна.
- Уг үзүүлэлт өмнөх оны мөн үед улсын хэмжээнд 2.5 сая төгрөг байсан бөгөөд 8.6 хувиар буурсан байна.


ББСБ-ЫН ХАРИЛЦАГЧИД



ЗЭЭЛДЭГЧИД /Насны бүлгээр/



ЗЭЭЛДЭГЧИД /Боловсролын түвшнээр/




ББСБ-ЫН АЖИЛЧИД



УЛСАД ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР



ББСБ-УУДЫН ТОО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР /давхардсан тоогоор/




БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

ОРЛОГО



ЗАРЛАГА




ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДЛЫН БҮРЭЛДЭХҮҮН

Эрсдэлийн сангийн зардал	ДҮН (тэрбум төгрөг)	ХУВЬ
Банк, санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал	2.0	1.7%
Үнэт цаасны эрсдэлийн сангийн зардал	–	0.0%
Зээлийн эрсдэлийн сангийн зардал	110.8	89.7%
Санхүүгийн түрээсийн эрсдэлийн сангийн зардал	–	0.0%
Факторингийн тооцооны авлагын эрсдэлийн сангийн зардал	2.9	2.4%
Авлагын эрсдэлийн сангийн зардал	0.6	0.5%
Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал	0.6	0.5%
Өмчлөх бусад санхүүгийн бус хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал	0.1	0.1%
Бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал (Авлагын эрсдэлийн сангийн зардал гэх мэт)	6.2	5.0%
НИЙТ	123.2	100.0%


ФАКТОРИНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Факторингийн үйлчилгээ эрхэлж буй 4 банк, 61 ББСБ байна. ББСБ-ууд факторингийн тооцооны авлага (цэврээр)-ын хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.0 дахин өсжээ.




ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Салбарын хэмжээнд 92 ББСБ итгэлцлийн үйлчилгээ эрхэлж байгаа бөгөөд тэдгээрийн татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 32.6 хувиар өссөн байна.



МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлж буй 56 ББСБ-аас 10 ББСБ нь тус үйлчилгээнээс орлого олсон нь өмнөх оны мөн үеэс 657.8 сая төгрөгөөр өссөн үзүүлэлт юм.



ГАДААД ВАЛҮТЫН МЭДЭЭ:

ББСБ-ууд тайлант улиралд 1,883.3 тэрбум төгрөгийн валют худалдан авч, 1,851.8 тэрбум төгрөгийн валют худалдсан байна. Нийт худалдаж авсан валютын 47.7 хувийг, худалдсан валютын 44.5 хувийг АНУ-ын ам.доллар бүрдүүлж байна.

Валютын нэр	Худалдаж авсан Дүн /тэрбум ₮/	Худалдсан Дүн /тэрбум ₮/
АНУ-ын ам.доллар	898.9	823.3
БНХАУ-ын юань	527.2	550.5
ОХУ-ын рубль	303.4	305.4
Евро	78.5	82.7
БНСУ-ын вон	34.0	37.3
Японы иен	22.1	30.5
Бусад	19.2	22.1

АШИГТ АЖИЛЛАГАА


НИЙТ ОРЛОГО
772.1 тэрбум
төгрөг
Өмнөх оны мөн үеэс
28.0 хувиар өссөн

НИЙТ ЗАРЛАГА
500.2 тэрбум
төгрөг
Өмнөх оны мөн үеэс
34.7 хувиар өссөн

ЦЭВЭР АШИГ
271.9 тэрбум
төгрөг
Өмнөх оны мөн үеэс
17.1 хувиар өссөн




НИЙТ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖИЙН ТАРХАЛТ




ROE болон ROA-ийн харгалзах интервал дахь ББСБ-ын тоо /хувиар/

Өмнөх оны мөн үеэс ББСБ-уудын нийт хөрөнгийн өгөөж 0.5 пунктээр, өөрийн хөрөнгийн өгөөж 0.8 хувиар тус тус буурсан. Нийт ББСБ-ын 32.5 хувь нь 1 хувиас доош, 40.5 хувь нь 1–5 хувийн, 19.9 хувь нь 5–10 хувийн, 7.1 хувь нь 10 хувиас дээш өөрийн хөрөнгийн өгөөжтэй ажиллалаа. Харин нийт хөрөнгийн өгөөжийн хувьд дээрх ангиллын харгалзах үзүүлэлтүүд нь тус тус 34.3, 46.5, 15.1, 4.2 хувь байна.



Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээр авч үзвэл 1.0 тэрбум төгрөгөөс доош хөрөнгөтэй ББСБ-уудын тал хувь нь 1.3 хувиас бага, 1–2.5 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй ББСБ-уудын тал хувь нь 2.0 хувиас бага, 2.5 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй ББСБ-уудын тал хувь нь 2.5 хувиас бага нийт хөрөнгийн өгөөжтэй ажилласан байна. Өөрийн хөрөнгийн өгөөжийн хувьд дээрх ангиллын харгалзах үзүүлэлтүүд 1.4, 2.2 болон 3.5 хувь байна.



ББСБ-уудын зарлага, орлогын харьцаа 64.8 хувь гарсан нь нэг төгрөгийн орлого олохын тулд дунджаар 0.65 төгрөгийн зардал гаргаж байгааг илэрхийлж байна. Энэ үзүүлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.3 пунктээр өссөн байна. Өөрөөр хэлбэл ББСБ-ууд 100 төгрөгийн орлого олохын тулд дунджаар 64.8 төгрөг зарцуулжээ.


ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

АFI-с боловсруулсан зөвлөмж зааврын дагуу санхүүгийн тогтвортой байдлыг дараах 4 үзүүлэлтийг тооцож тодорхойлдог. Үүнд:




ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САН

- Уг харьцаа 111.3 хувь гарсан нь байгуулбал зохих эрсдэлийн санг бүрдүүлж, эрсдэлийг 100.0 хувиас дээш түвшинд нөхөх чадамжтай болохыг илтгэж байна.




ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ

- Чанаргүй зээлийн хэмжээ 693.7 тэрбум төгрөгт хүрч нийт зээлд эзлэх хувь нь өмнөх оны мөн үеэс 2.2 пунктээр өссөн байна.




ХӨРВӨХ ЧАДВАРТАЙ ХӨРӨНГИЙН ХАРЬЦАА

- Хөрвөх чадвартай хөрөнгийн харьцаа өмнөх оны мөн үеэс 1.8 пунктээр өссөн байна.




Z ИНДЕКС

- Z индекс нь ББСБ-ын дампуурах магадлалыг илэрхийлдэг бөгөөд нийт хөрөнгийн өгөөж болон өөрийн хөрөнгийн харьцааны нийлбэрийг нийт хөрөнгийн өгөөжийн хэлбэлзэлд харьцуулж тооцдог үзүүлэлт юм. Z индексийн утга ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгийн хөшүүрэг өндөр үед өсөх, харин өгөөжийн хэлбэлзэл буюу орлогын тодорхойгүй байдал их үед буурах хандлагатай байдаг. Өөрөөр хэлбэл индексийн өндөр утга нь эрсдэл багатай, тогтвортой байдлыг илэрхийлдэг. Банк бус санхүүгийн салбарын Z индекс өмнөх оноос 2.0 нэгжээр буурсан байна.




НИЙТ ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖИЙН СТАНДАРТ ХАЗАЙЛТ



- Стандарт хазайлт гэдэг нь өгөгдлүүд дундаж хэмжээнээс хэр их өөрчлөгддөгийг илтгэдэг статистик үзүүлэлт юм.
- Нийт хөрөнгийн өгөөжийн стандарт хазайлтыг сүүлийн 4 улирлын өгөөж дээр суурилан тооцдог. Энэхүү стандарт хазайлтын утга их байх нь өгөөжийн хэлбэлзэл их харин бага байх нь өгөөж хэлбэлзэл бага буюу тогтвортой байгааг илэрхийлнэ.
- Уг утга өмнөх оны мөн үеэс 0.0020 нэгжээр өссөн байна


ФИНТЕК

	Нийт зээл		Зээлдэгчийн тоо		1 зээлдэгчид ногдох дундаж зээлийн хэмжээ /мян. төгрөг/
	Хэмжээ /тэрбум төг/	%	Тоо /мянга/	%	
Финтек	2,643.4	34.0%	3,191,501	92.0%	828.3
Уламжлалт	5,123.9	66.0%	275,970	8.0%	18,567.0
НИЙТ	7,767.3	100.0%	3,467,471	100.0%	2,240.1



ФИНТЕК ЗЭЭЛИЙН АНГИЛАЛ

Финтек зээлийн багцын 2.1 их наяд төгрөг нь хэвийн зээл, 181.7 тэрбум төгрөг нь анхаарал хандуулах зээл, 309.3 тэрбум төгрөг нь чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.




ФИНТЕК ХАРИЛЦАГЧИД



ББСБ-ын салбарын нийт харилцагчдын 93.4 хувь, нийт зээлдэгчдийн 92.0 хувь нь финтек үйлчилгээнд хамрагджээ.

ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ББСБ

Технологид суурилж зээл олгодог 7 ББСБ нь салбарын нийт зээлийн үлдэгдлийн 11.6 хувийг, олгосон зээлийн 27.5 хувийг, төлөгдсөн зээлийн 27.9 хувийг тус тус эзэлж байгаа нь эдгээр ББСБ-уудын зээлийн эргэлт сайн байгааг илтгэж байна.



НОГООН ЗЭЭЛ

16,757
зээлдэгч

Ногоон зээлийн үлдэгдэл: 16,757 зээлдэгчид олгосон ногоон зээлийн үлдэгдэл 132.9 тэрбум төгрөг байгаа нь тус салбарын нийт зээлийн үлдэгдлийн 1.7 хувийг эзэлж байна.

ОЛГОСОН ЗЭЭЛ

НОГООН ТАКСОНОМИ	Зээлийн үлдэгдэл /сая ₮/	Зээлдэгчдийн тоо
1. Эрчим хүчний хангамж, дэд бүтэц	10,352.0	7,438
2. Эрчим хүчний үр ашиг	24,101.1	3,383
3. Тогтвортой хот төлөвлөлт ба барилга	26,355.1	1,264
4. Бохирдлыг бууруулах ба сэргийлэх	97.5	7
5. Тогтвортой ус, хог хаягдал	636.3	49
6. Тогтвортой хөдөө аж, ахуй	2,867.7	134
7. Тогтвортой газар ашиглалт ба биологийн олон янз байдал	5,973.1	51
8. Нүүрс хүчлийн хийн ялгарал багатай тээвэр	40,831.3	1,620
9. Мэдээлэл, харилцаа холбоо, технологи	2,313.8	2,309
10. Эрүүл мэнд	11,052.7	258
11. Боловсрол, Соёл	4,948.5	219
12. Хүртээмжтэй дэд бүтэц	3,348.2	25
НИЙТ	132,877.3	16,757




88.9%
Хэвийн

4.0%
Хугацаа хэтэрсэн

7.1%
Чанаргүй

НҮҮРС ХҮЧЛИЙН ХИЙН ЯЛГАРАЛ БАГАТАЙ ТЭЭВЭР



ОЛГОСОН ЗЭЭЛ

Төрөл	Зээлийн дүн (сая ₮)	Зээлдэгчдийн тоо
1. Эрчим хүчний хангамж, дэд бүтэц	7,305.2	6,990
2. Эрчим хүчний үр ашиг	8,524.0	776
3. Тогтвортой хот төлөвлөлт ба барилга	4,611.7	283
4. Бохирдлыг бууруулах ба сэргийлэх	–	–
5. Тогтвортой ус, хог хаягдал	156.5	44
6. Тогтвортой хөдөө аж, ахуй	464.7	45
7. Тогтвортой газар ашиглалт ба биологийн олон янз байдал	391.5	11
8. Нүүрс хүчлийн хийн ялгарал багатай тээвэр	16,413.8	384
9. Мэдээлэл, харилцаа холбоо, технологи	1,501.7	2,173
10. Эрүүл мэнд	2,073.8	81
11. Боловсрол, Соёл	541.0	69
12. Хүртээмжтэй дэд бүтэц	102.5	12
Нийт	42,086.4	10,868

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

**Хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд:**

Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны 31 дүгээр тогтоолоор “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-д хэрэглээний зээлийн хэт өсөлтийг бууруулах, цахим зээлийн давхардлаас урьдчилан сэргийлэх хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Журмын өөрчлөлтийн хүрээнд дараах зохицуулалтыг тусгасан. Үүнд:

- ББСБ-аас олгох хэрэглээний зээлд тооцох өр, орлогын харьцаа 55 хувиас хэтрэхгүй байх;
- ББСБ нь хэрэглээний зээл олгох бүрд харилцагчийн зээлийн эрхийг тооцоолж, өр орлогын харьцааг хангасан эсэхийг шалгасны үндсэн дээр зээл олгох, ББСБ нь зээл олгосон тухай мэдээллийг бодит цагийн горимоор Зээлийн мэдээллийн санд нийлүүлэх;
- Зээлийн үйл ажиллагааны талаарх сурталчилгаанд зээлийн хүү болон зээлийн гэрээний үндсэн нөхцөлүүдийг тусгасан байх;
- Кредит карт, овердрафт эрхтэй харилцах данс эзэмшдэг зээлдэгчийн хувьд банк, санхүүгийн байгууллагаас тогтоосон зээлийн эрхийн 10 хувиар, финтек зээлийн шугамын эрхтэй зээлдэгчийн хувьд ББСБ-аас тогтоосон зээлийн эрхийн дүнгээр зээлийн төлбөрт тооцох;
- Харилцагчийн зээлийн лавлагаанд сүүлийн 72 цагийн дотор 5-аас доошгүй банк, санхүүгийн байгууллага зээл судалсан тухай бүртгэгдсэн тохиолдолд зээл судлах хугацааг 24 цагаар хойшлуулж, зээлийн лавлагааг шинэчлэн авсны үндсэн дээр зээл олгох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт
2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 68.1 хувь буюу 392 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 64.7 хувь буюу 372 ББСБ хэрэгжүүлсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

Зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ууд нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах, гэрээ байгуулж мэдээлэл солилцох үүрэгтэй.

Зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 514 ББСБ-ын 90.3 хувь буюу 464 ББСБ Монголбанк, “Бүрэн скор ЗМС” ХХК болон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК-ийн аль нэгтэй гэрээ байгуулсан байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

Тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “заасны дагуу 89 ББСБ 11,362 удаагийн тохиолдлоор 1,699.2 тэрбум төгрөгийг, 7.2-т заасны дагуу 3 ББСБ 22 удаагийн тохиолдлоор 1.2 тэрбум төгрөгийг Монголбанкны СМА-д тус тус мэдээлсэн бөгөөд хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

Нийт 578 ББСБ болон 1 банкнаас 1,496.0 сая төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төвлөрүүлэхээс 90.0 хувь буюу 522 ББСБ-аас 1,381.1 сая төгрөгийг Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО



ЗАХ ЗЭЭЛИЙН
ТӨЛӨВ

Нийт хөрөнгө

390.0 тэрбум
төгрөг

Хөрөнгийн өсөлт **5.9%**



ХҮРТЭЭМЖТЭЙ
БАЙДАЛ

Монгол Улсын 18–64 насны иргэдийн
25.0 хүн тутмын 1 нь ХЗХ–нд
гишүүнчлэлтэй байна.

Нийт гишүүдийн **44.3%**
дээд боловсролтой

43 салбартай



БҮТЭЭГДЭХҮҮН
ҮЙЛЧИЛГЭЭ

Нийт хадгаламж **271.3**

Нийт зээл **312.5**



АШИГТ АЖИЛЛАГАА

Нийт орлого

23.9 тэрбум
төгрөг

Улсад татан төвлөрүүлсэн
татвар, НДШ

1.4 тэрбум
төгрөг



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Чанаргүй зээлийн эзлэх хувь

4.4%







БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

ХЗХ–ДЫН ТОО БА ГИШҮҮД


- Тайлант улиралд Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)–дын тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4–өөр буюу 2.3 хувиар буурсан байна.
- ХЗХ–дын гишүүдийн тоо өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар өссөн.
- ХЗХ–дын тоог 2022 оны мөн үетэй харьцуулбал 16.1 хувиар буурсан бол гишүүдийн тоо 4.9 хувиар өсжээ.



НИЙТ ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ

Салбарын нийт хөрөнгийн:

- 90.8 хувийг 1 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 45 ХЗХ;
- 3.9 хувийг 500 саяас 1 тэрбум төгрөг хүртэл хөрөнгөтэй 22 ХЗХ;
- 5.3 хувийг 500 сая төгрөг хүртэл хөрөнгөтэй 105 ХЗХ эзэлж байна.





Хөрөнгийн ангилал	ХЗХ-дын тоо		Нийт хөрөнгө		Нийт зээл		Нийт хадгаламж		Гишүүдийн тоо	
	Тоо	%	Дүн /тэрбум ₮/	%	Дүн /тэрбум ₮/	%	Дүн /тэрбум ₮/	%	Тоо	%
Топ 25%	1	0.6%	88.6	22.7%	67.0	21.4%	57.4	21.1%	5,191.0	6.6%
Топ 50%	3	1.7%	190.4	48.8%	151.1	48.4%	134.3	49.5%	18,913.0	24.1%
Топ 75%	15	8.7%	290.8	74.6%	233.3	74.7%	210.4	77.6%	37,311.0	47.5%
НИЙТ	172	100%	390.0	100%	312.5	100%	271.3	100%	78,608.0	100%

ХЗХ-дын актив болон пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/

Нийт хөрөнгийн дүн	390.0	100.0%	
Санхүүгийн хөрөнгө	375.2	96.2%	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	50.5	12.9%	
Зээл /цэврээр/	321.0	82.3%	
Бусад санхүүгийн хөрөнгө	3.7	1.0%	
Санхүүгийн бус хөрөнгө	14.8	3.8%	
Татварын авлага	0.2	0.1%	
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага	0.0	0.0%	
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3.8	1.0%	
Бараа материал	0.4	0.1%	
Өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	0.5	0.1%	
Бусад санхүүгийн бус хөрөнгө	2.2	0.6%	
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө /цэврээр/	0.0	0.0%	
Үндсэн хөрөнгө /цэврээр/	5.2	1.3%	
Биет бус хөрөнгө /цэврээр/	2.5	0.6%	
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	390.0	100.0%	
Санхүүгийн өр төлбөр	297.7	76.3%	
Хадгаламж	290.3	74.4%	
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	2.1	0.5%	
Бусад санхүүгийн өр төлбөр	5.3	1.4%	
Санхүүгийн бус өр төлбөр	3.5	0.9%	
Өөрийн хөрөнгө	88.8	22.8%	
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	31.3	8.0%	
Өмчийн бусад хэсэг	0.7	0.2%	
Хоршоологчдын өмч	56.8	14.6%	

- Нийт хөрөнгийн 96.2 хувь нь санхүүгийн хөрөнгө, үлдсэн 3.8 хувь нь санхүүгийн бус хөрөнгө байна.
- Санхүүгийн хөрөнгийн бүрдлийг нийт хөрөнгөд эзлэх хувиар задалбал 12.9 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 82.3 хувийг цэврээр зээл, 1.0 бусад санхүүгийн хөрөнгө бүрдүүлж байна.
- Эх үүсвэрийн хувьд нийт хөрөнгийн 76.3 хувийг санхүүгийн өр төлбөр, 22.8 хувийг өөрийн хөрөнгө, 0.9 хувийг санхүүгийн бус өр төлбөр бүрдүүлж байна.

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ



- Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-ны тоо Улаанбаатар хотоос 12-оор их байна.
- Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын 42.4 хувь нь баруун бүсэд, 23.9 хувь нь төвийн бүсэд, 19.6 хувь нь хангайн бүсэд, 14.1 хувь нь зүүн бүсэд байршжээ.
- Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-дын 96.2 хувь нь төвийн зургаан дүүрэгт, 3.8 хувь нь алслагдмал гурван дүүрэгт байрлаж байна.




Чингэлтэй	16
Сүхбаатар	21
Баянгол	9
Сонгинохайрхан	6
Баянзүрх	14
Хан-Уул	11
Налайх	2
Багануур	1
Багахангай	0

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ийн улс орнуудын санхүүгийн хүртээмжийг үнэлэх үндсэн индикаторуудыг ашиглан салбарын хүртээмжтэй байдлыг хөдөлмөрийн насны буюу 18–64 насны 10,000 хүнд болон 1,000 аж ахуйн нэгж (ААН)-д ногдох ХЗХ-ны тоогоор тооцоолоход дараах байдалтай байна.

10 000 хүнд ногдох ХЗХ-ны тоо



10 000 хүнд ногдох ХЗХ-ны тоо



- 1,000 ААН-д ногдох ХЗХ-ны тоогоор Налайх дүүрэг болон Чингэлтэй дүүрэг тэргүүлж байгаа бол Баянгол дүүрэг тус үзүүлэлтээр хамгийн доогуур жагсаж байна.
- 10,000 хүнд ногдох ХЗХ-ны тоогоор Сүхбаатар болон Чингэлтэй дүүрэг тэргүүлж байна.

10 000 хүнд ногдох ХЗХ-ны тоо



1 000 ААН-д ногдох ХЗХ-ны тоо



Хүртээмжийн үзүүлэлтийг 4 бүсээр ангилахад 10,000 хүнд ногдох болон 1,000 ААН-д ногдох ХЗХ-ны тоогоор баруун бүс тэргүүлж байна.

ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

- Улсын хэмжээнд 18–64 насны 25 хүн тутмын нэг нь ХЗХ-нд гишүүнчлэлтэй, 66 хүн тутмын нэг нь зээлийн үйлчилгээ хүртжээ.
- Дээрх үзүүлэлт орон нутагт 58 хүн тутамд нэг, Улаанбаатар хотын хэмжээнд 77 хүнд нэг тохиож байна.
- Улсын хэмжээнд ХЗХ-ноос зээл авсан нэг гишүүн дунджаар 10.5 сая төгрөгийн зээлтэй.
- Улаанбаатар хотын хэмжээнд уг дүн 18.4 сая төгрөг, орон нутагт 5.0 сая төгрөг байна.




ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

- Улсын хэмжээнд 18–64 насны 39 хүн тутмын нэг нь ХЗХ–нд хадгаламжаа байршуулсан.
- Дээрх үзүүлэлт орон нутагт 43 хүнд нэг, Улаанбаатар хотын хэмжээнд 37 хүнд нэг тохиож байна.
- Улсын хэмжээнд ХЗХ–нд хадгаламж эзэмшигч нэг гишүүн дунджаар 5.5 сая төгрөгийн хадгаламжтай.
- Улаанбаатар хотын хэмжээнд энэ дүн 7.7 сая төгрөг, орон нутагт 3.0 сая төгрөг байна.




ХЗХ–НЫ ГИШҮҮДИЙН ХҮРТЭЭМЖ


Хүйсээр




Байршлаар



Насны бүлгээр



Боловсролын түвшнээр



Хадгаламж эзэмшигч 49,651



ЭМЭГТЭЙ
27,218 (54.8%)



ЭРЭГТЭЙ
22,242 (44.8%)



ХУУЛИЙН ЭТГЭЭД
191 (0.4%)



Зээлдэгчдийн тоо 29,658




ЭМЭГТЭЙ
16,001 (54.0%)



ЭРЭГТЭЙ
13,532 (45.6%)



ХУУЛИЙН ЭТГЭЭД
125 (0.4%)



Харьцаа

Хадгаламж эзэмшигчдийн тоо / Нийт гишүүдийн тоо

63.2%




Зээлдэгчдийн тоо / Нийт гишүүдийн тоо

37.7%




БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

ХЗХ-ДЫН ЗЭЭЛ




- Нийт зээл өмнөх оны мөн үеэс 31.3 тэрбум төгрөгөөр өссөн.
- 2022 оны мөн үетэй харьцуулбал нийт зээл 93.2 тэрбум төгрөгөөр буюу 42.5 хувиар нэмэгджээ.
- Цэвэр зээлийн хэмжээ 321.0 тэрбум төгрөгт, зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 7.4 тэрбум төгрөгт хүрсэн.

Зээлийн чанар





■ Чанаргүй зээл ■ Хугацаа хэтэрсэн зээл ■ Хэвийн зээл

- Хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 10.5 хувиар өсөж 287.4 тэрбум төгрөгт хүрлээ. Энэ нь нийт зээлийн 92.0 хувийг эзэлж байна.
- Хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 21.1 хувиар буурч 11.3 тэрбум төгрөг боллоо.
- Чанаргүй зээлийн хэмжээ 13.8 тэрбум төгрөгт хүрсэн нь 2022 оны мөн үеэс 2 дахин өсжээ.



Хуулийн этгээдийн зээлийн багцын 16.1 тэрбум төгрөгийг бичил, 6.5 төгрөгийг жижиг, 5.9 тэрбум төгрөгийн дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн зээл эзэлж байна.



- Нийт зээлийн 11.2 хувь нь хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаанд, 10.8 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээнд, 5.8 хувь нь санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаанд зориулж тус тус олгосон байна.
- Нийт эргэн төлөгдсөн зээлийн 12.2 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээнд, 7.8 хувийг санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаанд, 3.2 хувийг барилгын салбарт олгосон зээлээс төлөгджээ.
- Нийт хаагдсан зээлийн 23.9 хувь нь хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаанд, 9.7 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээнд, 4.6 хувь нь санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаанд зориулж олгосон зээл болно.

ХЗХ-ДЫН ХАДГАЛАМЖ

- Хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 13.5 тэрбум төгрөгөөр өслөө.
- 2022 оны мөн үетэй харьцуулбал 69.2 тэрбум төгрөгөөр буюу 34.2 хувиар нэмэгджээ.




- Хадгаламж эзэмшигчид ХЗХ-нд 264.1 тэрбум төгрөгийг хугацаатай, 7.2 тэрбум төгрөгийг хугацаагүй байршуулжээ.

- ХЗХ-дын 99.4 хувь нь 271.3 тэрбум төгрөгийн хадгаламж төвлөрүүлсэн.
- Үлдсэн 0.6 хувь нь хадгаламж татан төвлөрүүлээгүй байна.




НИЙТ ХАДГАЛАМЖИД ЭЗЛЭХ ХУВЬ

- 1 тэрбумаас дээш төгрөгийн хадгаламжтай ХЗХ-д 240.8 тэрбум төгрөгийн;
- 10 саяас 1 тэрбум төгрөгийн хадгаламжтай ХЗХ-д 30.4 тэрбум төгрөгийн;
- 10 саяас доош төгрөгийн хадгаламжтай ХЗХ-д 0.1 тэрбум төгрөгийн хадгаламжийг тус тус татан төвлөрүүлсэн.



ЖИГНЭСЭН ДУНДАЖ ХҮҮ



АШИГТ АЖИЛЛАГАА

ОРЛОГО

ХЗХ-дын хүүгийн орлогыг өмнөх онтой харьцуулахад 10.8 хувиар өсөж 22.9 тэрбум төгрөгт хүрлээ. Үүнд:

- Зээлийн хүүгийн орлого 21.2 тэрбум төгрөг;
- Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого 1.2 тэрбум төгрөг;
- Зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого 0.7 тэрбум төгрөг;
- Зээлийн хүүгийн орлогын буцаалт 0.2 тэрбум төгрөг.



ЗАРДАЛ


ХЗХ-дын хүүгийн зардлыг өмнөх онтой харьцуулахад 17.4 хувиар өсөж 12.7 тэрбум төгрөг болов. Үүнд:

- Хадгаламжийн хүүгийн зардал 12.6 тэрбум төгрөг;
- Банк, санхүүгийн байгууллагад төлсөн болон бусад хүүгийн зардал 0.1 тэрбум төгрөг;
- Санхүүгийн байгууллагад төлсөн болон бусад хүүгийн зардал 0.02 тэрбум төгрөг;
- Хүүгийн зардлын буцаалт 0.02 тэрбум төгрөг байна.




ХЗХ-ДЫН ОРЛОГО, ЗАРДАЛ

- ХЗХ-ны салбар 23.9 тэрбум төгрөгийн орлого олж, 20.6 тэрбум төгрөгийн зарлага гаргаж, 3.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.



НИЙТ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ


- Татварын дараах цэвэр ашгаар тооцоолоход ХЗХ-дын өөрийн хөрөнгийн өгөөж нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.6 пунктээр буурчээ.
- Нийт хөрөнгийн өгөөж 2022 оны мөн үетэй харьцуулахад 0.2 пунктээр буурсан бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад өөрчлөлтгүй байна.




ХЗХ-д улсын төсөвт нийт 1.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлээд байна.

ГОЛЛОХ ХАРЬЦААНУУД

- Хүүгийн орлогын нийт зээлд эзлэх хувь нь 2022 оны мөн үетэй харьцуулахад 0.3 пунктээр өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад өөрчлөлтгүй байна.
- Цэвэр орлогыг нийт орлогод харьцуулан тооцдог цэвэр ахиуц ашгийн харьцаа нь өмнөх оны мөн үеэс 2.2 пунктээр буурчээ.




- Үйл ажиллагааны зардал 2022 оны мөн үеэс 60.5 хувь, өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар тус тус өслөө.
- Үйл ажиллагааны зардал нийт орлогод эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.6 пунктээр буурлаа.



ЗАРДАЛ, ОРЛОГЫН ХАРЬЦАА

- ХЗХ-дын хувьд 100.0 төгрөгийн орлого тутамд 25.5 төгрөгийн үйл ажиллагааны зардал ногдож байна.




ТОГТВОРТОЙ БАЙДАЛ




ХЗХ-дын чанаргүй зээл

- Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өмнөх оны мөн үеэс 2.0 пунктээр өссөн. Энэ нь ХЗХ-дын мөрдөж буй зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болох 5 хувиас бага байх шаардлагыг хангаж байна.




ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН АНГИЛАЛ

- Чанаргүй зээлийн ангилалд багтах хэвийн бус зээлийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 18.2 пунктээр өссөн байна. Мөн эргэлзээтэй зээлийн хэмжээ 2.8 пунктээр өссөн бол муу зээлийн хэмжээ 21.0 пунктээр буурчээ.




ХЗХ–ДЫН ХӨРВӨХ ЧАДВАР

- ХЗХ–дын мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө болон нийт хөрөнгийн харьцаа өмнөх оны мөн үеэс 3.7 пунктээр буурлаа.
- Богино хугацаат хөрөнгө оруулалт болон нийт зээлийн нийлбэрийг нийт хөрөнгөд харьцуулсан үзүүлэлт өмнөх оны мөн үеэс 3.7 пунктээр өсжээ.



ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САН



- ХЗХ–дын зээлийн эрсдэлийн сангийн нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.5 пунктээр, харин нийт хөрөнгөд эзлэх хувь 0.5 пунктээр тус тус өссөн.

НОГООН ЗЭЭЛ

Ангилал	Хувь	Дүн (сая ₮)
СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ	4.1%	9.0
БАГА БОХИРДУУЛАГЧ ЭРЧИМ ХҮЧ	0.0%	0.0
ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ	0.0%	0.0
НОГООН БАРИЛГА	70.2%	154.1
БОХИРДЛООС СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	0.0%	0.0
ТОГТВОРТОЙ УС, ХАЯГДЛЫН ХЭРЭГЛЭЭ	22.8%	50.0
ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР АШИГЛАЛТ, ОЙ БОЛОН ЭКО АЯЛАЛ	2.9%	6.4
КАРБОН БАГА ТЭЭВЭР	0.0%	0.0
НИЙТ	100.0%	219.5

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН



Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.4 дэх заалтын хэрэгжилт

- Хуульд заасны дагуу 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор 2025 оны санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулж ирүүлбэл зохих 167 ХЗХ-оос 22.2 хувь буюу 37 ХЗХ жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэж Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэн.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

- Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 172 ХЗХ-ны 64.0 хувь буюу 110 ХЗХ зээлийн мэдээллийн санд хамрагдаж, үйлчилгээ үзүүлэгчтэй хамтран ажиллах гэрээг байгуулсан байна. Үүнээс 51.8 хувь буюу 57 ХЗХ нийслэлд, 48.2 хувь буюу 53 ХЗХ орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

“Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэл ирүүлэх журам”-ын хэрэгжилт

- Журмын 4.1-д заасны дагуу ГоАМЛ порталд 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт ХЗХ-дын 45.3 хувь буюу 78 ХЗХ бүртгүүлсэн байна.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

- Журмын дагуу зохицуулалтын үйлчилгээний хөлс төвлөрүүлбэл зохих 100 ХЗХ-оос 57 ХЗХ нийт 40,861.50 мянган төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА



Санхүүгийн зохицуулах хороо, Дэ нэйче консэрванси (TNC) байгууллагатай 2026 оны 03 дугаар 25-ны өдөр “Тогтвортой, ногоон санхүүжилтийг орон нутагт хөгжүүлэх чиглэл”-д хамтран ажиллахаар харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулж, уг санамж бичгийн хүрээнд 2026 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг мөн баталсан.

Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн 2025 оны хэрэгжилтийг дүгнэж, цаашид хамтран хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөгөөнд тусгасан.

ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ



Бичил санхүүгийн бодлогын зөвлөлийн ээлжит хурлыг 2026 оны 01 дүгээр 27-ны өдөр зохион байгууллаа.

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ



ЗАХ ЗЭЭЛИЙН
ТӨЛӨВ



ХҮРТЭЭМЖТЭЙ
БАЙДАЛ

Улаанбаатар **438**

Хөдөө орон нутаг **190**



БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТ


ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ /МЗҮАЭ/ ЭТГЭЭДИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Бүртгэсэн байгууллага	2025.I	2026.I
Санхүүгийн зохицуулах хороо	71	76
Аймаг, дүүргийн засаг дарга	443	552
Хуулийн этгээд	276	319
Иргэн	167	233

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч /МЗҮАЭ/ өмнөх оны мөн үеэс 114-өөр буюу 22.2 хувиар өссөн үзүүлэлтэй байна.

МҮЗҮАЭ-ийн 62.9 хувь нь хуулийн этгээд, 37.1 хувь нь иргэнээр бүртгүүлжээ.




ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

Хувь нийлүүлсэн хөрөнгө



МЗҮАЭ

- 100 сая ₮ хүртэл
- 101–300 сая ₮ хүртэл
- 301 сая ₮–1 тэрбум ₮ хүртэл
- 1 тэрбум ₮–с дээш

490
63
58
17



ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ



- МЗҮАЭ-ийн 69.7 хувь нь Улаанбаатар хотод, 30.3 хувь нь орон нутагт мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.
- Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй МЗҮАЭ-дийн 7.9 хувь нь баруун бүсэд, 53.2 хувь нь хангайн бүсэд, 30.0 хувь нь төвийн бүсэд, 8.9 хувь нь зүүн бүсэд байршжээ.
- Бүсээр нь авч үзвэл баруун бүсэд 11 иргэн, 4 хуулийн этгээд, хангайн бүсэд 82 иргэн, 19 хуулийн этгээд, төвийн бүсэд 20 иргэн, 37 хуулийн этгээд, зүүн бүсэд 8 иргэн, 9 хуулийн этгээдээр бүртгүүлсэн.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 438 МЗҮАЭ-дийн 98.9 хувь нь төвийн зургаан дүүрэгт, 1.1 хувь нь алслагдмал хоёр дүүрэгт байршиж байна.

МЗҮАЭ-дийн 25.1 хувь нь Баянзүрх, 22.1 хувь нь Баянгол, 17.8 хувь нь Сүхбаатар, 13.9 хувь нь Хан-Уул, 10.5 хувь нь Чингэлтэй, 9.4 хувь нь Сонгинохайрхан, 0.7 хувь нь Налайх, 0.5 хувь нь Багануур дүүрэгт тус тус байршиж байна.

Эдгээрийн 112 нь иргэн, 326 нь хуулийн этгээд болно.



Чингэлтэй	12	Хан-Уул	15
Сүхбаатар	5	Налайх	3
Баянгол	19	Багануур	4
Сонгинохайрхан	21	Багахангай	0
Баянзүрх	46		

МЗҮАЭ-ИЙН САЛБАРЫН ТАРХАЛТ



Улсын хэмжээнд 56 МЗҮАЭ-ийн 183 салбар үйл ажиллагаа эрхэлж байгаагийн 125 нь Улаанбаатар хотод, 58 нь хөдөө орон нутагт байршиж байна.

Үүний 102 нь Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн.

САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ

“Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)”-ийн улс орнуудын санхүүгийн хүртээмжийг үнэлэх үндсэн индикаторуудыг ашиглан салбарын хүртээмжтэй байдлыг тооцоолоход дараах байдалтай байна.

10 000 хүнд ногдох МЗҮАЭ-н тоо



1 000 ААН-д ногдох МЗҮАЭ-н тоо



- 1,000 ААН-д ногдох МЗҮАЭ-ийн тоогоор Багануур дүүрэг 11.5, Баянзүрх дүүрэг 8.1 үзүүлэлттэйгээр тус тус тэргүүлж байгаа бол Хан-Уул дүүрэг 5.3 гэсэн үзүүлэлттэйгээр хамгийн доогуур жагсаж байна.
- Хөдөлмөрийн насны буюу 18–64 насны 10,000 хүнд ногдох МЗҮАЭ-ийн тоогоор Баянзүрх, Сүхбаатар дүүргүүд тус тус 20.6, 10.2 гэсэн үзүүлэлтээр тэргүүлж байна.

<https://www.afi-global.org/sites/default/files/publications/fidwg-core-set-measuring-fi.pdf>

10 000 хүнд ногдох МЗҮАЭ-н тоо



1 000 ААН-д ногдох МЗҮАЭ-н тоо



Хүртээмжийн үзүүлэлтийг 4 бүсээр ангилахад 10,000 хүнд ногдох болон 1,000 ААН-д ногдох МЗҮАЭ-ийн тоогоор Хангайн бүс тэргүүлж байна.

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН



Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7 дахь заалт, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.3, 16.4 дэх хэсгийн хэрэгжилтийг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн өмчлөх эрх болон барьцаалан зээлдүүлэх газрын эрх ашгийг хамгаалах, түүнчлэн гэмт хэрэг, зөрчлийн улмаас алдагдсан эд зүйлсийн мэдээллийн цахим бүртгэлийн сан бүрдүүлж ашиглахтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А252 дугаар тушаалаар “Гэмт хэрэг, зөрчлийн улмаас алдагдсан эд зүйлсийг бүртгэх мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”-ыг баталсан.

Тус журмын 3.2-т зааснаар барьцаалан зээлдүүлэх газар нь барьцааны зүйл хүлээн авах бүрт мэдээллийн сантай тулгалт хийх, сэжиг бүхий эд зүйлсийн талаар цагдаагийн байгууллагад цахим болон харилцаа холбооны хэрэгслээр мэдэгдэх, гэмт хэрэг, зөрчлийн улмаас алдагдсан эд зүйлс болох нь цагдаагийн байгууллагаас тогтоосон тохиолдолд борлуулахгүй, үрэгдүүлэхгүй байх үүрэгтэй. Мөн өөрт хуримтлагдсан эд хөрөнгө, үйлчлүүлсэн иргэдийн талаарх мэдээлэл болон мэдээллийн сан ашиглах явцад олж авсан мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх үүргийг хүлээдэг.

Нийслэл, орон нутагт мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, дээрх журмын хэрэгжилтийг хангах зорилгоор Нийслэлийн цагдаагийн удирдах газар болон Эрүүгийн цагдаагийн Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэстэй хамтран дараах чиглэлд ажиллаж байна. Үүнд:

- www.mla.frc.mn цахим системд барьцааны зүйлийг бүрэн бүртгэж буй эсэхэд хяналт тавих;
- Барьцааны зүйлийг цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн улмаас алдагдсан эд зүйлийн сантай тулган баталгаажуулж байгаа эсэхэд хяналт тавих;
- Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүү эрх бүхий байгууллагаас тогтоосон дээд хэмжээнээс хэтэрсэн эсэхэд хяналт тавих;
- Шөнийн 22:00 цагаас өглөөний 06:00 цаг хүртэл үйл ажиллагаа явуулахгүй байх шаардлагын хэрэгжилтийг хангуулах;
- Насанд хүрээгүй болон согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн хүнд үйлчлэхгүй байх;
- Мөнгөн зээлийн үйл ажиллагаанаас өөр үйл ажиллагаа эрхлэхгүй байх;
- Бүртгэлгүйгээр мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийг илрүүлэх үзлэг, шалгалтыг зохион байгуулах;
- Бүртгэлгүйгээр мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхсэн нь тогтоогдсон этгээд зөрчил давтан үйлдэж байгаа эсэхэд хяналт тавих.

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН



ЗАХ ЗЭЭЛИЙН
ТӨЛӨВ

Нийт хөрөнгө

305.8 тэрбум
төгрөг



ХҮРТЭЭМЖТЭЙ
БАЙДАЛ

Батлан даалтын дундаж хэмжээ

54.5 сая төгрөг



БҮТЭЭГДЭХҮҮН
ҮЙЛЧИЛГЭЭ

Хүсэлтийн тоо **62**



АШИГТ
АЖИЛЛАГАА

Тайлант үеийн
ашиг/алдагдал

-3.5 тэрбум
төгрөг

Үндсэн үйл ажиллагааны орлого

1.7 тэрбум
төгрөг



ТОГТВОРТОЙ
БАЙДАЛ

Чанаргүй батлан даалтын
багцад эзлэх хувь

1.9%



БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТ

ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ


Өмнөх оны мөн үеэс

0.8% ↑

НИЙТ ХӨРӨНГӨ

305.8


Тэрбум төгрөг



■ Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/

Зээлийн батлан даалтын сан (ЗБДС)-ийн санхүүгийн зарим тоон үзүүлэлтийг өмнөх оны үетэй харьцуулбал:


- Нийт хөрөнгийн хэмжээ 0.8 хувь буюу 2.4 тэрбум төгрөгөөр өсөж;
- Батлан даалтын үлдэгдэл 3.7 хувь буюу 16.4 тэрбум төгрөгөөр буурч;
- Батлан даалт гаргасан зээлийн үлдэгдэл 3.6 хувь буюу 28.4 тэрбум төгрөгөөр өслөө.




■ Батлан даалтын үлдэгдэл

■ Батлан даалттай зээлийн үлдэгдэл

ОЛГОСОН БАТЛАН ДААЛТ



■ Батлан даалтын тоо



■ Батлан даалтын дүн /тэрбум төгрөг/


Олгосон батлан даалтын тоо өмнөх оноос

92.6% ↓

Олгосон батлан даалтын дүн өмнөх оноос

84% ↓

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ



БАТЛАН ДААЛТЫН ХЭМЖЭЭ /тэрбум төгрөгөөр/

Улсын
хэмжээнд

3.4

Зүүн бүс

1.1

Төвийн бүс

0.6

Хангайн бүс


1.5

Баруун бүс


0.2

НЭГ БАТЛАН ДААЛТЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ

- Тайлант улиралд Улсын хэмжээнд нэг зээлдэгчид ногдох батлан даалтын үлдэгдэл дунджаар 54.5 сая төгрөг байна.
- Бүс нутгуудын хувьд Хангай бүсэд нэг зээлдэгчид олгосон батлан даалтын дундаж үлдэгдэл хамгийн их буюу 80.8 сая төгрөг байна.



ХҮСЭЛТИЙН ТОО




Тайлант улиралд батлан даалт гаргуулахаар ирүүлсэн хүсэлтийн тоо өмнөх оны мөн үеэс 92.6 хувиар буурсан ба ирүүлсэн хүсэлтийн тоо 100 хувь шийдвэрлэгдсэн байна.

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ



Гаргасан батлан даалтын эх үүсвэрийн 1.9 тэрбумыг Азийн хөгжлийн банкны МОН-3338 төсөл, 1.3 тэрбумыг ипотек, 0.2 тэрбумыг банкны төсөл тус тус санхүүжүүлсэн болно.



БАТЛАН ДААЛТ ГАРГАСАН ДУНДАЖ ХУГАЦАА


- Гаргасан батлан даалтын дундаж хугацаа 261.4 сар буюу 21.8 жил байна.
- Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 188.8 сараар буюу 15.7 жилээр өссөн үзүүлэлт юм.

21.8
жил

Өмнөх оны мөн үеэс
15.7
жил


БАТЛАН ДААЛТ БАНКААР

Хаан банк 647.3 сая төгрөг, Худалдаа хөгжлийн банк 1,340.4 сая төгрөг, Төрийн банк 703.9 сая төгрөг, Голомт банк 373.0 сая төгрөг, Капитрон банк 238.7 сая төгрөг, Хас банк 48.4 сая төгрөг, Ариг банк 27.8 сая төгрөгийн батлан даалт тус тус гаргасан.





БАТЛАН ДААЛТТАЙ ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Нийт олгосон батлан даалттай зээлийн 8.3 хувийг бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа, 11.6 хувийг боловсруулах үйлдвэр, 10.3 хувийг зочид буудал байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, 59.5 хувийг ипотека, 10.3 хувийг бусад салбар эзэлж байна.




АШИГТ АЖИЛЛАГАА



НИЙТ ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ

ЗБДС-ийн нийт хөрөнгийн өгөөж -1.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.7 пунктээр сайжирсан үзүүлэлтэй байна.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ



ЧАНАРГҮЙ БАТЛАН ДААЛТЫН ҮЛДЭГДЭЛ

Өмнөх оны
мөн үеэс

2.2

тэрбум
төгрөг

ЧАНАРГҮЙ БАТЛАН ДААЛТЫН БАГЦАД ЭЗЛЭХ ХУВЬ


1.9%

Өмнөх оны
мөн үеэс

0.6

пункт

Чанаргүй батлан даалтын үлдэгдлийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилж үзвэл дараах байдалтай



- Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ
- Боловсруулах үйлдвэр
- Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур
- Зочид буудал байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ
- Барилга
- Бусад

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ



ЗАХ ЗЭЭЛИЙН
ТӨЛӨВ

Зохицуулалттай этгээд

298



ХҮРТЭЭМЖТЭЙ
БАЙДАЛ

95.6% Улаанбаатар хотод үйл
ажиллагаа эрхэлж байна.



БҮТЭЭГДЭХҮҮН
ҮЙЛЧИЛГЭЭ

ҮХЭХЗ-ын
борлуулалтын дүн
794.8 тэрбум
төгрөг



БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТ



ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ



Тайлант улиралд ҮХЭХЗ-ын нийт 298 байгууллага тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4-өөр буурсан байна.



Брокерын тоо 312 болж, өмнөх оны мөн үеэс 7-гоор буурсан бол агентын тоо 1,338 болж, өмнөх оны мөн үеэс 127-оор өсжээ.






Нэг ҮХЭХЗ-ын байгууллага дунджаар 1 брокер, 4 агенттай ажиллаж байна. Хамгийн олон агенттай ҮХЭХЗ-ын байгууллагын агентын тоо 92 байна.


ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

ҮХЭХЗ-ын байгууллагууд нь 437 хувьцаа эзэмшигчдийн 6.0 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувьцаа эзэмшигчдийн тоо 0.9 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгө 15.5 хувиар тус тус буурсан байна.




ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

ҮХЭХЗ-ын байгууллагын хувьцаа эзэмшигчдийн бүтцийг авч үзвэл 93.3 хувийг иргэд, 5.4 хувийг хуулийн этгээд, үлдсэн 1.3 хувийг иргэн хуулийн этгээд хамтран эзэмшиж байна.



Тайлант улиралд нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 14.3 хувь буюу 864.3 сая төгрөгийг гадаадын хөрөнгө оруулалт эзэлж байна.


85.7%
Дотоод хөрөнгө оруулалт



14.3%
Гадаад хөрөнгө оруулалт

НИЙТ ХӨРӨНГӨ

ҮХЭХЗ–ын байгууллагуудын нийт хөрөнгө 214.8 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүний 162.7 тэрбум төгрөг буюу 75.7 хувийг эргэлтийн хөрөнгө, үлдсэн 52.1 тэрбум төгрөг буюу 24.3 хувийг эргэлтийн бус хөрөнгө, эх үүсвэрийн 173.3 тэрбум төгрөг буюу 80.7 хувийг өр төлбөр, 41.5 тэрбум төгрөг буюу 19.3 хувийг эздийн өмч тус тус эзэлж байна.



Нийт хөрөнгө
2.6%↓


ҮХЭХЗ–ын байгууллагуудын нийт хөрөнгө 214.8 тэрбум төгрөг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ

ҮХЭХЗ–ын байгууллагуудын нийт хөрөнгийн 75 хувийг 15 компани, 93 хувийг 60 компани бүрдүүлж байна.

Нийт хөрөнгийн дүнгээр зах зээлд эзлэх хувийг авч үзвэл 1 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 30 компани 85.5 хувийг, 500 сая төгрөгөөс 1 тэрбум төгрөг хүртэл хөрөнгөтэй 14 компани 4.4 хувийг, 100 сая төгрөгөөс 500 сая төгрөг хүртэл хөрөнгөтэй 74 компани 7.6 хувийг, 100 сая төгрөг хүртэл хөрөнгөтэй 180 компани 2.5 хувийг тус тус бүрдүүлж байна.

БАЙГУУЛЛАГУУДЫН ТОО




ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ




Чингэлтэй	8.4%
Сүхбаатар	34.0%
Баянгол	10.2%
Сонгинохайрхан	0.7%
Баянзүрх	19.3%
Хан-Уул	27.4%

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ


ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ, ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ



ҮХЭХЗ-ын байгууллагууд 3,045 хэлцлээр, 641.2 мянган м.кв талбай бүхий ҮХЭХ-ийг 794.8 тэрбум төгрөгөөр зуучлан худалдан шилжүүлж, 21.9 тэрбум төгрөгийн зуучлалын хөлс олжээ.



ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН ТҮРЭЭС



641.2 мянган м.кв талбай бүхий ҮХЭХ-ийг 794.8 тэрбум төгрөгөөр худалдан борлуулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад талбайн хэмжээ 2.0 дахин, үнийн дүн 47.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ҮХЭХЗ–ЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ, ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ



Худалдсан ҮХЭХ–ийн талбайн хэмжээгээр 72.2 хувийг газар, 24.1 хувийг орон сууц, 2.8 хувийг арилжааны зориулалттай, 0.6 хувийг үйлдвэрийн зориулалттай, 0.3 хувийг автозогсоол тус тус эзэлж байна.





Шигтгээ:

Тайлант улиралд нийтийн орон сууцны 1 м.кв–ын дундаж үнэ 4.0 сая төгрөг, тансаг зэрэглэлийн орон сууцны 1 м.кв–ын дундаж үнэ 9.3 сая төгрөг байна.


ТҮРЭЭСЛЭХ, ТҮРЭЭСЛҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ



ҮХЭХЗ-ын байгууллагууд 2,283 хэлцлээр 165.3 мянган м.кв талбай бүхий ҮХЭХ-ийг 61.4 тэрбум төгрөгөөр түрээслүүлж, 4.4 тэрбум төгрөгийн зуучлалын хөлс олжээ.



ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН ТҮРЭЭС



165.3 мянган м.кв талбай бүхий ҮХЭХ-ийг 61.4 тэрбум төгрөгөөр түрээсэлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад талбайн хэмжээ 9.6 хувиар, үнийн дүн 4.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

ҮХЭХЗ-ЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТҮРЭЭСЛЭХ, ТҮРЭЭСЛҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ




Түрээсэлсэн ҮХЭХ-ийн талбайн 65.8 хувийг орон сууц, 26.5 хувийг арилжааны зориулалттай, 5.9 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай, 1.0 хувийг газар, 0.8 хувийг автозогсоол тус тус эзэлж байна.




ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН МЕНЕЖМЕНТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



ҮХЭХЗ-ын байгууллагууд 883 хэлцлээр 82.7 мянган м.кв талбай бүхий ҮХЭХ-ийг 2.4 тэрбум төгрөгийн менежментийн үйлчилгээ үзүүлж 1.5 тэрбум төгрөгийн зуучлалын хөлс олжээ.



82.7 мянган м.кв талбай бүхий ҮХЭХ-ийг 2.4 тэрбум төгрөгөөр менежментийн үйлчилгээ үзүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад талбайн хэмжээ 10.1 хувиар, үнийн дүн 63.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



АШИГТ АЖИЛЛАГАА

Тайлант улиралд ҮХЭХЗ-ын байгууллагууд 53.8 тэрбум төгрөгийн орлого олж, 51.9 тэрбум төгрөгийн зарлага гаргаж, 1.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан.



Ашигтай 100 байгууллага

7.7 тэрбум төгрөг

33.5 %

100/298

Ашиг, алдагдалгүй 67 байгууллага

0 ₮

22.5%


67/298

Алдагдалтай 131 байгууллага

5.8 тэрбум төгрөг

44.0%

131/298



ROE болон ROA-ийн харгалзах интервал дахь ҮХЭХЗ-ын байгууллагуудын тоо

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН



Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 648 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад зөвшөөрөл, эрх олгоход тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон журам”-ын нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулж, Захиргааны ерөнхий хуулийн 62.1-д заасны дагуу салбарын оролцогчид болон олон нийтээс санал авахаар журмын төслийг Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудаст байршуулсан.

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын олон улсын хууль, эрх зүйн орчны судалгаа хийх, хуулийн төсөл боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргаар 2026 оны 03 дугаар сарын 06-ны өдөр батлуулав.

ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ



Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх хяналт шалгалтын цаглаварт “Орон сууц захиалах, худалдан авах харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн биелэлтийн талаар мэдээлэл сонсох” ажиллагаа хийхээр тусгасан. Тус ажлын хүрээнд Орон сууц захиалгын гэрээний маргаан гарч байгаа тохиолдлуудын шалтгааныг нэгтгэн дүн шинжилгээ хийх, уг гэрээний харилцаатай холбоотой маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэх, хохирлыг бууруулах, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал солилцох зорилгоор 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдөр холбогдох төрийн байгууллага, Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбоо, судлаачдын төлөөллийг оролцуулсан “Санал солилцох уулзалт” зохион байгуулагдсан бөгөөд уг уулзалтад Санхүүгийн зохицуулах хорооны Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газрын төлөөлөл оролцож ажиллалаа.

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын агентад эрх олгох сургалтыг 3 удаа зохион байгуулж, тус сургалтад 261 оролцогчийг хамруулсан бөгөөд брокерт эрх олгох сургалтыг 1 удаа зохион байгуулж, 14 оролцогч хамрагдлаа.

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧ



ЗАХ ЗЭЭЛИЙН
ТӨЛӨВ

Арилжаа эрхлэгчдийн тоо

54 хуулийн этгээд
522 иргэн



ХҮРТЭЭМЖТЭЙ
БАЙДАЛ

Нийт арилжаа эрхлэгч иргэдийн

377 буюу **72.2%** нь
Улаанбаатар хотод үйл ажиллагаа
эрхэлж байна.



БҮТЭЭГДЭХҮҮН
ҮЙЛЧИЛГЭЭ


202.5 тэрбум
төгрөг
үнэт металл
худалдан авсан.



БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТ


ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД



ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ


2026 оны 1 дүгээр улирлын байдлаар тусгай зөвшөөрөл бүхий 54 арилжаа эрхлэгч хуулийн этгээд нь 84 хувьцаа эзэмшигчийн 6.5 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувьцаа эзэмшигчийн тоо 4-өөр, хувь нийлүүлсэн хөрөнгө 36.3 хувиар тус тус буурсан байна.



ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

Тусгай зөвшөөрөлтэй арилжаа эрхлэгч иргэдийн 377 буюу 72.2 хувь нь Улаанбаатар хотод, 145 буюу 27.8 хувь нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.


УЛААНБААТАР ХОТ
377



ОРОН НУТАГ
145

Дүүрэг	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээд	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд
Баянзүрх дүүрэг	3	22
Баянгол дүүрэг	7	33
Чингэлтэй дүүрэг	16	273
Хан-Уул дүүрэг	12	13
Сонгинохайрхан дүүрэг	2	15
Сүхбаатар дүүрэг	13	21


ОРОН НУТАГТ АРИЛЖАА ЭРХЛЭГЧ ИРГЭД ТОО




БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

ХУДАЛДСАН БОЛОН ХУДАЛДАН АВСАН ҮНЭТ МЕТАЛЛ

Тайлант улиралд 408.3 кг үнэт металлыг 202.5 тэрбум төгрөгөөр худалдан авч, 429.9 кг үнэт металлыг 208.9 тэрбум төгрөгөөр худалдан борлуулсан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан үнэт металлын үнийн дүн 5.7 дахин, худалдсан үнэт металлын үнийн дүн 6.0 дахин өссөн үзүүлэлттэй байна.



ХУДАЛДАЖ АВСАН БОЛОН ХУДАЛДСАН ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА





ХӨРӨНГӨ, ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ

ҮМҮЧЭТХЭАЭ 54 байгууллагын нийт хөрөнгө 104.4 тэрбум төгрөг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



АШИГТ АЖИЛЛАГАА

ҮМҮЧЭТХЭАЭ 54 байгууллага 3.7 тэрбум төгрөгийн тайлант үеийн цэвэр ашигтай ажилласан ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН



Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд болон Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд нарын 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/10, А/127 дугаар хамтарсан тушаалаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл ажиллаж байна. Тус ажлын хэсгийн хүрээнд 2026 оны 03 дугаар сарын 19–22-ны өдрүүдэд Сэлэнгэ, Дархан–Уул, Төв аймагт “Хууль бусаар ашигт малтмал олборлохоос урьдчилан сэргийлэх” сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан ба Санхүүгийн зохицуулах хорооноос бичил уурхай эрхлэгч нарт холбогдох зөвлөгөө, мэдээллийг өгч ажилласан. Тус сургалтад эрдэс баялаг, бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нийт 130 иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан.

Санхүүгийн зохицуулах хорооноос Монгол банктай хамтран үнэт металл, үнэт чулуу, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй иргэдийн үнэт металлын борлуулалтыг нэмэгдүүлэх, байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэдээлэл солилцоог эрчимжүүлэх чиглэлээр уулзалт зохион байгуулав.

Гаалийн ерөнхий газраас 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан “Үнэт металл, эрдэнийн чулууны экспорт, импорт, гаалийн бүрдүүлэлт, тусгай зөвшөөрөл, хууль бус этгээдээс урьдчилан сэргийлэх, анхаарах асуудлууд” сэдэвт сургалт, мэдээллийн арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл оролцож, холбогдох мэдээлэл, танилцуулга хийж ажиллалаа.

СЭНДБОКСЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН



ЗАХ ЗЭЭЛИЙН
ТӨЛӨВ

Нийт ирүүлсэн **25**
хүсэлт
Туршигдаж буй компани **4**

Сэндбоксын орчинд амжилттай
туршигдсан компани **3**



РЕПО ХЭЛЦЭЛ
ЗУУЧЛАЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭ

2,550
удаагийн хэлцэл

Нийт арилжааны дүн
560.4 тэрбум
төгрөг



Р2Р ЗЭЭЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ

Харилцагчид

11,968

4.4 тэрбум
төгрөг



В2В ЗЭЭЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ

Бүртгэлтэй
харилцагчид **345**

197.1 тэрбум
төгрөг

Р2Р ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Р2Р зээлийн үйлчилгээ нь 2022 оны арван хоёрдугаар сард сэндрбоксын зохицуулалтын орчинд орсон бөгөөд хиймэл оюун ухаан, блокчэйн технологийг зээлийн үнэлгээ, бүртгэлдээ ашиглан хөрөнгө оруулагч, зээлдэгч хоёрыг шууд холбох үйлчилгээг хөгжүүлэн туршиж байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ

2.1%

ЗЭЭЛДЭГЧ

97.9%


НИЙТ ХАРИЛЦАГЧДЫН ТОО

11,968



Р2Р ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХАРИЛЦАГЧИД

Платформоор нийт 11,968 харилцагчдад Р2Р зээлийн үйлчилгээг үзүүлсэн бөгөөд эдгээр харилцагчдын 2.1 хувь нь хөрөнгө оруулагч, үлдсэн 97.9 хувь нь зээлдэгч байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хөрөнгө оруулагчдын эзлэх хувь 0.6 хувиар өссөн байна.



Р2Р ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗЭЭЛИЙН ДҮН

Р2Р зээлийн үйлчилгээний платформоор нийт 4.4 тэрбум төгрөгийн зээл олгогдсон бөгөөд тайлант улирлын байдлаарх Р2Р үйлчилгээний нийт зээлийн үлдэгдэл 97.9 сая төгрөг байна. Нийт зээлийн 75.0 хувийг 3 сараас бага хугацаатай зээл, 25.0 хувийг 3 сараас дээш хугацаатай зээл эзэлж байна. Харин тус платформоор дамжсан хөрөнгө оруулалтын багцын 35.0 хувийг 1 жил болон түүнээс дээш хугацаатай, 65.0 хувийг 1 жилээс бага хугацаатай хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна.



1 –12 сарын
хугацаатай

Олгосон
зээлийн дүн

4.4
тэрбум төгрөг

Зээлийн үлдэгдэл

97.9 сая



Зээлийн ЖДХ 2%

P2P зээлийн үйлчилгээний нийт харилцагчдын 63.7 хувь нь эмэгтэй, 36.3 хувь нь эрэгтэй харилцагчид байна.

Эрэгтэй
36.3%




Эмэгтэй
63.7%

P2P платформоор зуучлагдан олгогдсон нийт зээлийн 98.9 хувь нь хэвийн, 0.5 хувь нь хугацаа хэтэрсэн, 0.6 хувь нь чанаргүй зээл байна.


ХЭВИЙН ЗЭЭЛ



ХУГАЦАА ХЭТЭРСЭН ЗЭЭЛ




ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ




P2P платформоор зуучлагдан олгогдсон нийт зээлийн 98.9 хувь нь хэвийн, 0.5 хувь нь хугацаа хэтэрсэн, 0.6 хувь нь чанаргүй зээл байна. Мөн P2P зээлийн сарын жигнэсэн дундаж хүү 2.0 хувьтай байна.

Харин нийт харилцагчдын 49.6 хувийг 18–35 насныхан, 34.5 хувийг 36–45 насныхан, 12.8 хувийг 46–55 насныхан, 3.1 хувийг 55–аас дээш насныхан тус тус бүрдүүлж байна.

НАСНЫ БҮЛГЭЭР



Харилцагчдыг боловсролын түвшнээр ангилбал 62.0 хувь нь дээд, 4.1 хувь нь тусгай дунд, 29.5 хувь нь бүрэн дунд, 4.2 хувь нь дунд, 0.2 хувь нь бага боловсролтой байна.




МӨНГӨНИЙ ЗАХЫН АРИЛЖАА

Мөнгөний захын арилжааны платформ нь 2021 оны арван хоёрдугаар сард сэндрокс орчинд орсон бөгөөд банк бус санхүүгийн байгууллагуудын репо хэлцлийн арилжаа, хадгаламжийн сертификат, арилжааны бичиг, факторинг, итгэлцлийн үйлчилгээнд суурилсан мөнгөний захын хэрэгслийг арилжаалах, төлбөр тооцоо, бүртгэл, хадгалалтын нэгдсэн платформыг хөгжүүлэн туршиж байна.


ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТ

2023 оны есдүгээр сараас эхлэн тайлант улирлыг хүртэлх байдлаар нийт 849.1 сая төгрөгийн Хадгаламжийн сертификат арилжаалагдсан байна.

Анхдагч арилжааны дүн



Хоёрдогч арилжааны дүн



ИТГЭЛЦЭЛ

2023 оны аравдугаар сараас эхлэн тайлант улирлыг хүртэлх байдлаар нийт 16.2 тэрбум төгрөгийн итгэлцлийн үйлчилгээг зуучилсан байна.


Анхдагч арилжааны дүн



Хоёрдогч арилжааны дүн



РЕПО ХЭЛЦЭЛ



Репо хэлцлийн арилжааг эхлүүлснээс хойш тус платформ дээр 56 зээлдүүлэгч, 47 зээлдэгч нийт 560.4 тэрбум төгрөгийн 2,550 удаагийн арилжаа хийгдсэн байна.

Тайлант улиралд репо зээлийн дундаж хугацаа 46 хоног, дундаж хүү 19.1 хувьтай байна.

РЕПО ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ХУГАЦАА 46 ХОНОГ



РЕПО
ЗЭЭЛИЙН
ДУНДАЖ
ХҮҮ

19.1%

РЕПО ХЭЛЦЛИЙН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Хугацаа	Зээлдүүлэгчийн тоо	Зээлдэгчийн тоо	Арилжааны тоо	Арилжааны дүн	Дундаж хүү (%)	Зээлийн дундаж хугацаа
2023.I	18	14	149	30,120,000,000	17.3	31
2024.I	21	20	139	34,350,000,000	17.7	37
2025.I	19	27	149	32,450,000,000	18.0	40
2026.I	29	27	189	52,190,000,000	19.1	46

Репо хэлцлийн үзүүлэлтүүдээс харахад 2026 онд зээлийн дундаж хүү болон зээлийн дундаж хугацаа өмнөх жилүүдтэй харьцуулахад тогтвортой өсөх хандлагатай байна. Тухайлбал, зээлийн дундаж хүү 2023 онд 17.3 хувь байсан бол 2026 онд 19.1 хувь болж нэмэгдсэн нь зах зээл дэх санхүүжилтийн өртөг өсөж байгааг илтгэж байна. Зээлийн дундаж хугацаа мөн хугацаанд 31 хоногоос 46 хоног болж 15 хоногоор уртассан нь оролцогчид илүү урт хугацаатай санхүүжилт эрэлхийлэх болсон, улмаар зах зээл богино хугацаанаас дунд хугацааны бүтэц рүү шилжиж буйг харуулж байна.

Түүнчлэн зээлдүүлэгчдийн тоо 29, зээлдэгчдийн тоо 27 болж өссөн нь тус зах зээлийн эрэлт, нийлүүлэлт нэмэгдэж байгааг харуулж байна. Арилжааны тоо 149–189 хооронд хэлбэлзэж байгаа ч нийт дүн 30.12 тэрбум төгрөгөөс 52.19 тэрбум төгрөг болж 70 гаруй хувиар өссөн нь нэг хэлцлийн дундаж хэмжээ нэмэгдэж, зах зээлийн санхүүжилтийн багтаамж эрчимтэй тэлж буйг харуулж байна.

РЕПО ХЭЛЦЛИЙН ХҮҮГИЙН ТҮВШИН БА АРИЛЖААНЫ ДҮН

/сая төгрөг, хугацаа/



Нийт репо хэлцлийн 27.6 хувийг 4 долоо хоногийн хугацаатай, 42.8 хувийг 12 долоо хоногийн хугацаатай, 20.5 хувийг 2 долоо хоногийн хугацаатай, 9.1 хувийг 1 долоо хоногийн хугацаатай репо зээлүүд тус тус эзэлж байна.

В2В ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

В2В зээлийн үйлчилгээ нь 2024 оны нэгдүгээр сард сэндроксын орчинд орсон бөгөөд аж ахуй нэгжүүдийн богино хугацаат санхүүжилтийн хэрэгцээг хангах, байгууллагуудын харилцах дансанд буй илүүдэл нөөцийг эргэлтэд оруулах замаар зах зээл дэх эх үүсвэрийг үр ашигтайгаар ашиглах боломжийг олгон зээлдэгч, хөрөнгө оруулагчийг холбох үйлчилгээг туршиж байна.

В2В зээлийн хугацаа (хоног)



В2В зээлийн дундаж хүү



Олгосон зээлийн дүн

197.1 тэрбум
төгрөг

Санхүүжилтийн дүн

146.1 тэрбум
төгрөг



Бүртгэлтэй харилцагчийн тоо

345

В2В зээлийн үйлчилгээний платформд бүртгэлтэй 345 харилцагч байгаа бөгөөд 197.1 тэрбум төгрөгийн зээл тус платформоор зуучлагдсанаас 180.0 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдсөн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тус платформоор олгосон зээлийн дүн 2.7 дахин өссөн үзүүлэлттэй байна.

В2В зээлийн жигнэсэн дундаж хүү нь 1.5 хувь, хугацааны хувьд 7, 14, 21, 28, 42, 91 гэсэн хоногуудтай байна.

БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ



Оролцогчдоос ирсэн тайлан мэдээнд суурилан зайны хяналтыг тогтмол гүйцэтгэн, газар дээрх хяналт, үзлэгийг мөн гүйцэтгэн ажиллаж байна.

Сэндбоксад туршигдаж буй 4 байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээ тус бүрд тохирсон тайлан, мэдээний маягтыг боловсруулан 7 хоног, сар, улирлын тайлан, мэдээг төвлөрүүлэн тоон мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна.

Сэндбоксад туршигдаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний олон улс дахь хөгжил, зохицуулалтын орчны судалгааг тогтмол гүйцэтгэн ажиллаж байна.

Кэмбриджийн Их сургуулийн дэргэдэх Суптек Лабын төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хөтөлбөрт хамрагдахаар болсон бөгөөд тус хөтөлбөрийн хүрээнд ХБНГ Улсад төвтэй “Регноложи” компанитай “Санхүүгийн зохицуулах хороонд суптек нэвтрүүлэх” стратеги төлөвлөгөөг боловсруулах чиглэлд хамтран ажиллаж байна.

Бүс нутгийн сэндбоксын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, бүс нутгийн сэндбокс нэвтрүүлэхэд анхаарах асуудлуудын талаар Төв Азийн төлөөллүүдтэй хамтран ажиллаж байна.

СЭНДБОКСЫН ОРЧНЫГ ОЛОН НИЙТЭД ТАНИУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Санхүүгийн зохицуулах хороо үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ойн хүрээнд “Санхүүгийн инновац ТекСпринт–2026” уралдааныг амжилттай зохион байгуулав. Санхүүгийн инновац текспринт нь санхүүгийн салбар дахь инновацыг дэмжих, олон нийтэд технологид суурилсан санхүүгийн зах зээл болон сэндбокс зохицуулалтын үйл ажиллагааг таниулах, санхүүгийн зах зээлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, цахим технологид суурилсан ухаалаг, тогтвортой, хүртээмжтэй санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд чиглэсэн шинэ санаа, инновацлаг шийдлүүдийг тодруулах зорилготой арга хэмжээ юм. Энэ удаагийн уралдаан нь хариуцлагатай зээлийн үйл ажиллагааг дэмжих, хэрэглэгчдэд санхүүгийн ухаалаг шийдвэр гаргах, өр төлбөрөө зөв зохицуулахад чиглэсэн технологид суурилсан шийдлүүдийг хөгжүүлэхэд төвлөрсөн бөгөөд нийт 27 багийн 108 оролцогч бүртгүүлснээс эцсийн шатанд шалгарсан 11 баг шийдлүүдээ танилцуулан өрсөлдлөө.

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЗАХ ЗЭЭЛ



ЗАХ ЗЭЭЛИЙН
ТӨЛӨВ

Виртуал хөрөнгийн
үйлчилгээ үзүүлэгч

12



ХҮРТЭЭМЖТЭЙ
БАЙДАЛ

Харилцагчийн тоо

724,671



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

Дотоодын виртуал хөрөнгийн
өдрийн дундаж арилжаа

340.0 сая төгрөг



АШИГТ АЖИЛЛАГАА

Нийт орлого

0.9

тэрбум төгрөг

Алдагдал

2.2

тэрбум төгрөг




БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ

Тус салбарт 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч (ВХҮҮ) үйл ажиллагаа эрхэлж байна. ВХҮҮ-ийн тоо сүүлийн дөрвөн жилийн хугацаанд өөрчлөлтгүй, тогтвортой байна.


ВХҮҮ-ийн тоо



Үйл ажиллагааны чиглэл		ВХҮҮ
	Виртуал хөрөнгийг шилжүүлэх	12/12
	Нэг болон олон төрлийн виртуал хөрөнгийг хооронд нь арилжих	10/12
	Виртуал хөрөнгө, албан ёсны мөнгөн тэмдэгт хооронд арилжих	12/12
	Виртуал хөрөнгө, түүнд хамаарах хэрэгслийг хадгалах, удирдах	12/12
	Виртуал хөрөнгийг нийтэд санал болгох, худалдахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүгийн үйл ажиллагаанд оролцох болон үйлчилгээ үзүүлэх	10/12

ХУВЬЦАА ЭЗЭМШЛИЙН БҮТЭЦ


Нийт 23 хувьцаа эзэмшигчтэй бөгөөд үүнээс 14 нь 50 хувиас дээш хувьцаа эзэмшдэг тул хувьцаа эзэмшлийн бүтэц нь төвлөрсөн шинжтэй байна.




ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ВХҮҮ–д 724,671 харилцагч бүртгэлтэй байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 23.0 хувиар буурсан үзүүлэлт юм.

ХАРИЛЦАГЧДЫН ТОО




Баталгаажуулалт хийсэн



Бүртгэлтэй харилцагчдын 66.8 хувь нь баталгаажуулалт хийсэн харилцагчид байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.1 хувиар өссөн үзүүлэлт юм.

Идэвхтэй харилцагчид



Арилжаанд идэвхтэй оролцож байгаа харилцагчдын тоо нь өмнөх оны мөн үеэс 59.8 хувиар өссөн үзүүлэлт юм.

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

ДОТООДЫН ВИРТУАЛ ХӨРӨНГӨ

ВХҮҮ-ийн арилжааны самбарт 36 дотоодын виртуал хөрөнгө арилжаалагдаж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар буурсан үзүүлэлт юм.

Дотоодын виртуал хөрөнгийн тоо



37

2025.I



36

2026.I

ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ (тэрбум төгрөг)

2023.I 384.3

2024.I 168.7

2025.I 167.0

2026.I 188.9

Дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үеэс 21.9 тэрбум төгрөг буюу 13.1 хувиар өссөн.

Дотоодын виртуал хөрөнгийн арилжаа (тэрбум төгрөг)

Виртуал хөрөнгийн арилжааны дүн

өмнөх оны
мөн үеэс

90.8%↑

71.0

2023.I

27.1

2024.I


16.0

2025.I

30.6


2026.I

ӨДРИЙН ДУНДАЖ АРИЛЖАА (сая төгрөг)



Дотоодын виртуал хөрөнгийн хувьд өдрийн дундаж арилжаа өмнөх оны мөн үеэс 161.8 сая төгрөгөөр өссөн байна.

АРИЛЖААНЫ БҮТЭЦ



Дотоодын виртуал хөрөнгийн арилжааны 59.4 хувийг SPC, 26.3 хувийг ARDX, 12.3 хувийг INC, 2.0 хувийг бусад виртуал хөрөнгүүд бүрдүүлж байна.

ГАДААДЫН ВИРТУАЛ ХӨРӨНГӨ


ВХҮҮ-ийн арилжааны самбарт арилжаалагдаж буй гадаадын виртуал хөрөнгө өмнөх оны мөн үеэс 70.0 хувиар өссөн.

ГАДААДЫН ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ТОО




Гадаадын виртуал хөрөнгийн арилжаа (тэрбум төгрөг)

Виртуал хөрөнгийн арилжааны дүн өмнөх оны мөн үеэс **60.2%↓**




ӨДРИЙН ДУНДАЖ АРИЛЖАА (тэрбум төгрөг)



Гадаадын виртуал хөрөнгийн хувьд өдрийн дундаж арилжаа 1.8 тэрбум төгрөг байна.

АРИЛЖААНЫ БҮТЭЦ

Гадаадын виртуал хөрөнгийн арилжааны 51.0 хувийг USDT, 13.1 хувийг MONT, 7.3 хувийг SOL, 28.6 хувийг бусад виртуал хөрөнгүүд бүрдүүлж байна.



АШИГТ АЖИЛЛАГАА



НИЙТ ОРЛОГ

0.9

тэрбум төгрөг

Өмнөх оны мөн үеэс
1.4 тэрбум төгрөгөөр буюу
61.4 хувь буурсан.



НИЙТ ЗАРЛАГА

3.1

тэрбум төгрөг

Өмнөх оны мөн үеэс
1.2 тэрбум төгрөгөөр буюу
28.0 хувь буурсан.




АШИГ / АЛДАГДАЛ

(2.2)

тэрбум төгрөг

Өмнөх оны мөн үеэс
178.1 сая төгрөгийн
алдагдалтай ажиллажээ.


НИЙТ ХӨРӨНГӨ (тэрбум төгрөг)



30.3% ↓


Салбарын нийт хөрөнгө **23.0** тэрбум төгрөг
өмнөх оны мөн үеэс **30.3%** ↓

ХӨРӨНГИЙН БҮТЭЦ



Нийт хөрөнгийн 42.1 тэрбум төгрөг нь эргэлтийн хөрөнгө, 10.9 тэрбум төгрөг нь эргэлтийн бус хөрөнгө байна.

ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ



Нийт эх үүсвэрийн 42.7 тэрбум төгрөг нь өр төлбөр, 10.3 тэрбум төгрөг нь эздийн өмч эзэлж байна.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2024.I	2025.I	2026.I
Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/	11,800.3	12,826.4	13,690.1
Зах зээлийн үнэлгээ / ДНБ	17.1%	16.0%	15.2%
Хөрвөх чадвар	1.0%	0.4%	0.5%
Хувьцааны арилжаа /тэрбум төгрөг/	128.5	47.9	68.9
Компанийн өрийн хэрэгслийн арилжаа /тэрбум төгрөг/	42.6	49.3	42.5
ХБҮЦ–ны арилжаа /тэрбум төгрөг/	16.7	74.6	97.6
Хөрөнгө оруулалтын сан /тэрбум төгрөг/	17.2	34.6	79.9
Засгийн газрын үнэт цаас /тэрбум төгрөг/	–	–	60.0
ТОП–20 индекс	44,693.58	50,171.38	52,126.33
MSE A индекс	17,799.40	19,422.59	20,154.75
MSE B индекс	12,207.55	14,729.13	14,438.18
ХК–ийн тоо	309	311	307
ҮЦК–ийн тоо	51	54	52
ХАА–н биржийн арилжааны дүн /тэрбум төгрөг/	59.5	53.3	77.2
Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны дүн /тэрбум төгрөг/	2,488.1	667.4	2,369.8

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2024.I	2025.I	2026.I
Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/	582.3	591.1	804.1
Даатгалын болон давхар даатгалын нийт хураамж /тэрбум төгрөг/	110.0	110.0	143.4
Нийт нөхөн төлбөр /тэрбум төгрөг/	35.8	49.1	47.9
Нөөц сан /тэрбум төгрөг/	270.5	320.3	370.2
Давхар даатгалын хураамж /тэрбум төгрөг/	35.2	26.5	44.8
Цэвэр ашиг /тэрбум төгрөг/	8.3	14.4	10.2
Эздийн өмч	225.8	267.6	320.0
Мэргэжлийн оролцогчид:			
Ердийн даатгал	16	17	18
Урт хугацааны даатгал	2	2	3
Давхар даатгал	1	1	1
Даатгалын төлөөлөгч	2,462	2,622	1,118
Даатгалын зуучлагч	63	62	64
Хохирол үнэлэгч	25	29	27
Актуарч	40	40	41
Аудитор	147	151	153
Аудитын компани	45	47	47

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2024.I	2025.I	2026.I
ББСБ–ын тоо	531	575	578
Үүнээс: УБ хот	436	479	478
Хөдөө, орон нутаг	95	96	100
Харилцагчдын тоо	4,457,031	3,739,282	4,347,995
Нийт хөрөнгө	5,062.1	7,568.4	9,570.9
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	588.2	662.1	1,005.3
Хөрөнгө оруулалт	57.6	89.5	143.6
Нийт зээл (цэврээр)	4,037.4	6,263.3	7,619.8
Факторингийн тооцооны авлага	20.9	51.9	103.8
Үүсмэл санхүүгийн хөрөнгө	1.6	4.7	3.3
Бусад санхүүгийн хөрөнгө	113.3	152.0	235.2
Санхүүгийн хөрөнгийн дүн	4,819.0	7,223.5	9,111.0
Санхүүгийн бус хөрөнгийн дүн	243.1	344.9	459.9
Нийт өр төлбөр	2,144.5	3,683.7	4,435.8
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	759.1	1,196.1	1,585.5
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	705.5	1,423.8	1,480.5
Бусад эх үүсвэр	374.0	702.9	712.8
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	0.8	4.2	2.1
Бусад санхүүгийн өр төлбөр	91.8	142.8	331.9
Хоёрдогч өглөг	0.6	2.2	86.1
Давуу эрхийн хувьцаа	–	–	1.3
Санхүүгийн өр төлбөрийн дүн	1,931.8	3,472.0	4,200.2
Санхүүгийн бус өр төлбөрийн дүн	212.7	211.7	235.6
Өөрийн хөрөнгө	2,917.6	3,884.7	5,135.1
Нийт орлого	378.1	603.4	772.1
Нийт зардал	232.2	371.3	500.2
Нийт цэвэр орлого	145.9	232.1	271.9

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТООН МЭДЭЭЛЭЛ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2025.1	2026.1
Нийт хөрөнгө	368.3	390.0
Санхүүгийн хөрөнгө	356.1	375.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	61.2	50.5
Зээл /цэврээр/	289.2	321.0
Нийт зээл	281.2	312.5
Хэвийн зээл	260.1	287.4
Хугацаа хэтэрсэн зээл	14.2	11.3
Чанаргүй зээл	6.9	13.8
Бусад санхүүгийн хөрөнгө	5.7	3.7
Дансны авлага /цэврээр/	0.9	1.1
Санхүүгийн бус хөрөнгө	12.2	14.8
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	368.3	390.0
Санхүүгийн өр төлбөр	286.6	297.7
Хадгаламж	275.1	290.3
Нийт хадгаламж	257.8	271.3
Хугацаагүй хадгаламж	6.7	7.2
Хугацаатай хадгаламж	251.1	264.1
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	4.3	2.1
Бусад санхүүгийн өр төлбөр	7.2	5.3
Санхүүгийн бус өр төлбөр	3.6	3.5
Өөрийн хөрөнгө	78.1	88.8
Хуримтлагдсан орлого, алдагдал	18.5	22.0
Нийт орлого	21.4	23.9
Хүүгийн орлого	20.6	22.9
Хүүгийн бус орлого	0.4	0.5
Үйл ажиллагааны бусад орлого, олз	0.4	0.5
Нийт зарлага	17.9	20.6
Хүүгийн зардал	10.8	12.7
Эрсдэлийн сангийн зардал	1.0	1.5
Үйл ажиллагааны зардал	5.7	6.1
Бусад зардал, гарз	0.1	0.0
Орлогын албан татварын зардал	0.3	0.3
Цэвэр орлого	3.5	3.3
ХЗХ–дын тоо	176	172
УБ ХЗХ–дын тоо	84	80
Орон нутаг ХЗХ–дын тоо	92	92
Гишүүдийн тоо	77,557	78,608

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2024.1	2025.1	2026.1
Нийт хөрөнгө	293.3	303.4	305.8
Батлан даалтын үлдэгдэл	108.6	447.6	431.2
Үүнээс: Хугацаа хэтэрсэн	1.7	4.0	12.3
Чанаргүй	5.8	6.0	8.2
Батлан даалт гаргасан зээлийн үлдэгдэл	221.9	782.8	811.2
Үүнээс: Хугацаа хэтэрсэн	2.3	3.9	12.0
Чанаргүй	19.3	17.1	15.4
Үндсэн үйл ажиллагааны орлого	2.0	2.8	1.7
Үндсэн үйл ажиллагааны зардал	4.3	14.2	5.2
Тайлант үеийн цэвэр үр дүн	(2.3)	(11.4)	(3.5)
Батлан даалт авахаар ирүүлсэн хүсэлтийн тоо	170	841	62
Олгосон батлан даалтын тоо	163	841	62
Олгосон батлан даалтын дүн	17.1	21.2	3.4
Үүнээс: Хөдөө аж ахуй	0.3	0	0
Үйлдвэрлэл	2.9	1.0	0.4
Бөөний болон жижиглэн худалдаа	7.6	0.4	0.4
Бусад	6.3	19.8	2.6
Батлан даалт гаргасан дундаж хугацаа /сараар/	225.3	72.6	261.4

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН САЛБАРЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2024.І	2025.І	2026.І
ҮХЭХЗ–ын байгууллагын тоо	310	302	298
Брокерын тоо	323	319	312
Агентын тоо	1,304	1,211	1,338
Худалдаж, худалдан авч, шилжүүлсэн ҮХХ–ийн талбайн хэмжээ /мянган м.кв/	289.7	316.2	641.2
Худалдаж, худалдан авч, шилжүүлсэн ҮХХ–ийн үнэ /тэрбум ₮/	508.6	538.5	794.8
Түрээслүүлж, түрээсэлж, хөлслүүлж, хөлсөлсөн ҮХХ–ийн талбайн хэмжээ /мянган м.кв/	158.3	150.8	165.3
Түрээслүүлж, түрээсэлж, хөлслүүлж, хөлсөлсөн ҮХХ–ийн үнэ /тэрбум ₮/	51.9	58.9	61.4

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2024.1	2025.1	2026.1
Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо	52	55	54
Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн тоо	434	485	522
Худалдан авсан үнэт металлын бохир жин /грамм/	340.1	282.1	408.3
Худалдан авсан үнэт металлын нийт үнэ /тэрбум ₮/	55.1	35.6	202.5
Худалдсан үнэт металлын бохир жин /грамм/	229.1	193.1	429.8
Худалдсан үнэт металлын нийт үнэ /тэрбум ₮/	47.1	34.8	208.9
Худалдан авсан эдлэлийн нийт үнэ /тэрбум ₮/	5.8	5.8	4.7
Худалдсан эдлэлийн нийт үнэ /тэрбум ₮/	9.6	12.6	7.7

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

ҮЗҮҮЛЭЛТ	2024.І	2025.І	2026.І
Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тоо /улирлаар/	12	12	12
Харилцагчийн тоо	875,082	941,180	724,671
Идэвхтэй арилжаа хийдэг	16,639	11,748	18,770
Баталгаажуулалт хийсэн	353,904	464,939	484,021
Дотоодын виртуал хөрөнгийн тоо	47	37	36
Дотоод виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/	168.7	167.0	188.9
Дотоодын виртуал хөрөнгийн арилжааны дүн /тэрбум төгрөг/	27.1	16.0	30.6
Дотоодын виртуал хөрөнгийн өдрийн дундаж арилжаа /сая төгрөг/	300.8	178.2	340.0
Гадаадын виртуал хөрөнгийн тоо		403	685
Гадаадын виртуал хөрөнгийн арилжааны дүн /тэрбум төгрөг/	376.0	401.2	159.5
Гадаад виртуал хөрөнгийн өдрийн дундаж арилжаа /тэрбум төгрөг/	4.2	4.5	1.8
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /тэрбум төгрөг/	24.9	24.9	24.9
Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/	57.9	76.0	53.0
Эргэлтийн хөрөнгө /тэрбум төгрөг/	37.9	58.2	42.1
Эргэлтийн бус хөрөнгө /тэрбум төгрөг/	20.1	17.8	10.9
Өр төлбөр /тэрбум төгрөг/	33.8	54.5	42.7
Эздийн өмч /тэрбум төгрөг/	24.1	21.5	10.3
Нийт орлого /тэрбум төгрөг/	5.6	2.3	0.9
Нийт зардал /тэрбум төгрөг/	2.6	4.3	3.1
Ашиг / Алдагдал /тэрбум төгрөг/	3.0	(2.0)	(2.2)

